

МАЛ ЭМНЭЛГИЙН ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНД ЗОРИУЛАН ДЭЭЖ АВАХ, БЭЛТГЭХ, ХАДГАЛАХ, ИЛГЭЭХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Мал амьтан халдварт, паразитгах, халваргүй өвчин, хордлогын сэжигтэйгээр өвчлөх, үхэж хорогдох үед түүний шалтгааныг тогтоох, оношлох зорилгоор амьд болон үхсэний дараа эмгэгт материал авч сум орон нутаг, цаашилбал аймаг, бүс, улсын мал эмнэлэг ариун цэврийн лабораторид илгээж шинжлүүлнэ. Мал, амьтны өвчлөл, үхлийн шалтгааныг тогтооход нэмэлт баталгаа, тодруулга болгох зорилгоор гадаад орчноос дээж авч болно.

1.2. Эмгэгт материал, дээж авч лабораторид хүргүүлэх нь аливаа өвчнийг оношлох, оношийг батлах, тандах; эрүүл мэндийн баталгаа гаргах; вакцинжуулалтын үр дүнг хянах; эмчилгээ, урьдчилан сэргийлэлт, эрүүлжүүлэх арга хэмжээний үр дүнг үнэлэх, дүгнэх; мал эмнэлгийн ариун цэвэр-эрүүл ахуйн хяналт үнэлгээ хийх зэрэг үйл ажиллагааны үндэс болно.

1.3. Мал, амьтнаас эмгэгт материал, дээж авах ажлыг зөвхөн малын эмч гардан гүйцэтгэх бөгөөд шинжилгээний дээж авах, түүнийг лабораторид хүргүүлэхдээ энэхүү журам болон мал, амьтны халдварт, паразитгах, халдваргүй, хордлогот өвчинтэй тэмцэх зааврыг мөрдлөг болгоно. Лабораторийн шинжилгээний эцсийн дүн, дүгнэлт нь эмгэгт материал, дээжийг зөв сонгож авах, савлах, тогтворжуулах, хадгалах, тээвэрлэх зэргээс бүхэлдээ шалтгаалдаг учир энэхүү журам болон дээр дурьдсан зааврын холбогдох заалтыг чанд мөрдөж ажиллана.

1.4. Эмгэгт материал авч лабораторид хүргүүлэхэд дараах ерөнхий зарчмыг баримтлана.

1.4.1. Эпизоотологийн байдал, эмнэл зүйн шинж тэмдэгийн илрэл, эмгэг хувиралтыг үндэслэн тавьсан урьдчилсан оношид тулгуурлан шинжлүүлэх өвчинд тохирох эмгэгт материал, дээжийг оновчтой сонгон хүрэлцэх хэмжээгээр авч зөв савлан тогтворжуулан тээвэрлэж лабораторид хүргүүлнэ.

1.4.2. Өвчний эмнэл зүйн шинж тэмдэг болон эмгэг бие бүтцийн хувиралт тод илэрч үхсэн мал, амьтнаас эмгэгт материал, дээж авна.

1.4.3. Эмгэгт материалыг зөвхөн ариутгасан багаж хэрэглэн ариун саванд авна. Эрхтэн, эдийн огтолж авах хэсгийн гадаргыг урьдчилан дөлөөр шарах юм уу халаасан хавтгай төмрөөр хайрсны дараа зүсэж авна.

1.4.4. Эд, эрхтэнээс авсан дээжийг “нэг дээж - нэг сав” гэсэн зарчмыг чанд баримтлан тус тусад нь савлана. Савны гадна мал, амьтны төрөл, мөн дээжийн нэр, эсвэл дээжийн бүртгэлийн дугаарыг бичнэ.

1.4.5. Вакцин, ийлдэс тарьсан, эмчилгээ хийсэн мал, амьтдаас аль болох дээж авахгүй байхыг хичээх ба хэрэв авбал дагавар бичигт ямар вакцин, ийлдэс, эмийн бодис хэдийд хэрэглэсэн болохыг заавал бичсэн байна.

1.4.6. Эмгэгт материалыг мал, амьтан үхсэнээс хойш 2 цагийн дотор авах ба энэ шаардлагыг дулааны улиралд заавал баримтлана.

1.4.7. Хүүрийн өөрчлөлт орсон, ялзарч муудсан үед авсан, эсвэл хадгалалт тээвэрлэлтийн явцад ялзарч муудсан дээж шинжилгээнд хэрэглэхгүй.

1.4.8. Шинжилгээнд авсан эмгэгт материалыг 24-30 цагийн дотор хадгалааслалгүйгээр +4 доош хэм бүхий хөргөгч юмуу хөлдөөгч гелль бүхий сав ашиглан хүргэнэ.

- 1.4.9. Шинжлүүлэх өвчинд тохируулан эмгэгт материал, ~~дээж~~-тогтворжуулагч уусмалыг зөв сонгож хэрэглэнэ.
- 1.4.10. Эмгэгт материалыг эд эрхтний эмгэг хувиралттай хэсгээс, эд судлалын шинжилгээний дээжийг эд, эрхтний эрүүл ба хувиралттай хэсгийн заагаас тус тус авна.
- 1.4.11. төрлийн шинжилгээ хийлгэх бол хүрэлцэхүйц хэмжээний дээж авна.
- 1.4.12. Ийлдэс судлалд цусны дээжийг анх өвчилсөн мал, амьтныг оролцуулаад 10-аас цөөнгүй мал, амьтнаас авах ба “нэг зүү-нэг мал” гэсэн зэрчмыг хатуу баримтлана.
- 1.4.13. Өөрөө халдвар авах, халдвар тараахаас сэргийлэн эрүүл ахуйн шаардлага, биоаюулгүйн ажиллагааны нөхцлийг бүрэн хангасан байна.
- 1.4.14. Дээж авч байгаа мал, амьтныг стрессэд оруулах, бэртэхээс сэргийлнэ.
- 1.4.15. Задлан хийх бүрд эмгэг бие бүтцийн тэмдэглэл бүрэн хөтлөнө.

Хоёр. Дээж авах ажлын бэлтгэл

2.1. Дээж авах эмч нь дор дурьдсан зүйлсийг бүрэн зэхэж бэлтгэл хангасан байна.

Хамгаалалтын хувцас	Задлан хийх багаж, хэрэгсэл	Дээжийн сав
<ul style="list-style-type: none"> - Ардаа зөрүүлэгтэй урт ханцуйтай халад юмуу нэг удаагийн хамгаалалтын хувцас; - Малгай; - амны хаалт эсвэл хошуувч; - нүдний шил буюу нүүрний хаалт; - зузаан резин бээлий, ханцуйвч; - хормогч; - усны гутал; 	<ul style="list-style-type: none"> - Эмгэг бие бүтцийн задалгааны хурц хутга; - тахир болон гэдэсний хайч; - скальпель түүний солих ирнүүд; - анатомийн хямсаанууд; - Гар болон цахилгаан хөрөө; - алх, цүүц; - эд, эрхтэн гаргах хулдаасан дэвсгэр; - түмпэн; 	<ul style="list-style-type: none"> - вакутайнерын зүү; - зүү баригч; - ЭДТА/ гепаринтай вакутайнерын хуруу шил 50–аас цөөнгүй; - энгийн вакутайнерын хуруу шил 50–аас цөөнгүй; - Ийлдэс 2 мл–ийн кариотюбе 50–аас цөөнгүй; - нэг удаагийн тариур (3,5,10 мл) зүүний хамт 5 аас дээш тооны; - тогтворжуулагч уусмал бүхий дээжийн 10–50 мл–ийн сав 10–20 ш; - 10%-формалины уусмал бүхий дээжийн 50–100 мл–ийн сав 10–20 ш; - Бодисын шил 20 ш; - Зузаан гялгар уут 10 ш; - Пергаментан цаас - Хүүр задлалтын тэмдэглэлийн хуудас; - Харандаа, бал; - Хөргөгч, хөлдөөгч;

Гурав. Дээж тогтворжуулагч уусмал бэлтгэх, хэрэглэх, хадгалах

3.1. Тогтворжуулагч уусмалыг зөв сонгож хэрэглэнэ.

3.1.1. Үхрийн мялзангийн дээжийг глицерин бүхий уусмалд тогтворжуулан хадгалж болохгүй.

3.1.2. Нян, вирус, паразит өсгөвөрлөх дээжийг формалины уусмалд тогтворжуулан хадгалж болохгүй.

3.2. Нян судлалын шинжилгээнд зориулсан дээжийг хөргөгчид хадгалах ба 48 цагийн дотор лабораторид хүргүүлэх ба хөлдөөж явуулж болно.

3.2.1. Нян судлалын шинжилгээ хийх эмгэгт материалыг 3.10–д заасан глицерины 30%-ийн уусмалд тогтворжуулан хадгалж болно.

- 3.2.2. Тархийг бүтнээр нь дээж болгон авсан үед тууш уртааш нь хоёр хэсэг болгож нэг хэсгийг нь шинээр нь мөсөнд, нөгөө хэсгийг формалины уусмалд тогтворжуулан хадгална.
- 3.2.3. Микоплазм, риккетси, хламид, лептоспирын шинжилгээний дээжийг хөлдөөж болохгүй. +4°C-д долоогоос илүүгүй хоног хадгалж тээвэрлэнэ.
- 3.2.4. Нян, мөөгөнцрийн хор, биохими, хор судлалын шинжилгээнд зориулсан дээжийг ямар нэгэн тогтворжуулагч уусмал хэрэглэлгүй хөлдөөж 2 хоногийн дотор лабораторид хүргэнэ.
- 3.3. Вирус судлалын шинжилгээ хийх эмгэгт материал, дээжийг 3.7.2, 3.7.3, 3.7.7, 3.7.8 –д заасан уусмалд тогтворжуулан хадгалах бөгөөд хөлдөөж болохгүй.
- 3.3.1. Вирус өсгөвөрлөх дээжийг –20°C-д удаан хугацаагаар хадгалбал вирус үхэх учир –70°C-д хадгалах нь илүү тохиромжтой.
- 3.4. Гистологийн шинжилгээ хийх дээжийг 3.7-д заасан тогтворжуулагч уусмалд хадгална.
- 3.4.1. Формалинд тогтворжуулан хадгалсан эд, эрхтнийг хөлдөөж болохгүй.
- 3.4.2. Дээжийн хэмжээ 1,5x2x2 см байх ба тогтворжуулагч уусмал нь дээжээсээ 4–5 дахин их байна.
- 3.4.3. Формалинд бэхжүүлсэн эд, эрхтэнтэй хамт цус, түрхэц, эд, эрхтний дээж байлгаж болохгүй.
- 3.5. Гадна, дотно шимэгчийн дээжийг 3.7.5, 3.7.6-д заасан тогтворжуулагч уусмалд хадгална.
- 3.5.1. Паразит судлалд явуулах баасны дээж дэх цагаан хорхойн өндөг авгалдай болохоос сэргийлж хөргөгч юм уу хөлдөөгч гель бүхий саванд хийж 24 цагийн дотор лабораторид хүргүүлнэ.
- 3.5.2. Баасны дээжийг резин бөглөөтэй хуруу шил юм уу саванд хийж болохгүй. Тээвэрлэлтийн явцад хий үүсэх тул бөглөө нь мултарч унах аюултай.
- 3.5.3. Баасыг тээвэрлэх орчинд юм уу +4°C-д тээвэрлэнэ.
- 3.5.4. Жижиг гельминтийг Барбаголлын уусмалд, хачиг, шавьж, туузан хорхой, том нематодыг 70%-ийн этанолд тогтворжуулан хадгална.
- 3.6. Ийлдэс судлалд зориулан ийлдсийг –20°C-д хөлдөөж хадгалах буюу тээвэрлэнэ.
- 3.6.1. Эсвэл борын хүчлийн ханасан уусмал (борын хүчил 3,0 гр + физиологийн уусмал 100 мл) 9:1 харьцаагаар нэмж тогтворжуулах, эсвэл 0,01%-ийн мерталат натригаар тогтворжуулж +4°C-д хадгалж болно. Мөн 0.1 мл цус юм уу ийлдсийг 0.5x0.5 см хэмжээтэй шүүлтүүр цаасанд шингээж хатаагаад тээвэрлэж болно.
- 3.6.2. Бусад урвалд зориулсан ийлдсийн дээжийг –20°C-д хөлдөөх буюу 0,01%-ийн мерталат натригаар тогтворжуулан +4°C-д хадгална.
- 3.7. Тогтворжуулагч уусмалыг дараах жороор бэлтгэнэ.
- 3.7.1. **Формалины 10%-ийн буфержүүлсэн уусмал.** Формалин (формальдегидын 40 %-ийн уусмал) нэг хэсэг дээр фосфат буферын давсны уусмал (рН 7.6) 9 хэсгийг нэмж бэлтгэнэ.
- 3.7.2. **Фосфат буферын давсны уусмал.** Натри хлорид (NaCl) 8.5 г, кали хлорид (KCl) 0.20 г, фосфат натри (Na₂ HPO₄) 0.56 г, фосфат кали (KH₂PO₄) 0.74 г-ийг нэрмэл усанд уусгаж 800 мл хүртэл ус нэмнэ.
- 3.7.3. **Глицеринтэй тогтворжуулагч орчин.** Фосфат буферын давсны уусмалыг автоклавдаж ариутгасны дараа ариун глицериныг 1:1-ийн харьцаагаар хольж 1 литрт тооцож пенициллин G 2x10⁶ нэгж/л, стрептомицин 200 мг/л, полимиксин В 2x10⁶ нэгж/л, гентамицин 250 мг/л, нистатин 0.5x10⁶ нэгж/л, офлоксацин HCl 60 мг/л-ийг нэмнэ.
- 3.7.4. **Глицерины 30%-ийн уусмал.** 140 мл фосфат буферын давсны уусмал дээр глицерин 60 мл (рН 7.2–7.4) нэмнэ.

- 3.7.5. **Барбаголлын уусмал.** 97 мл физиологийн уусмал дээр формалин (формальдегидын 40 %-ийн уусмал) 3 мл–ыг нэмнэ.
- 3.7.6. **70⁰-ийн этанол.** 96⁰-ийн этанол 70 мл–ийг авч дээр нь 26 мл нэрмэл ус нэмнэ.
- 3.7.7. **Вируст материал тээвэрлэх антибиотиктой уусмал.** Хенксийн орчин 86 мл + 10%-ийн альбумин 10 мл, 5.6 %-ийн NaHCO₃ уусмал 1,5 мл + пенициллин 10 нэгж/мл–0.5 мл + стрептомицин 10 мг/мл 1 мл + нистатин 2,500 нэгж/мл–1 мл + 0.4 %-ийн фенол улаан 0.5 мл (рН 7.2)
- 3.7.8. **Вируст материал тээвэрлэх 199 тэжээлт орчин.** Үхрийн альбумин 0.5 % агуулсан эсийн өсгөврийн 199 тэжээлт орчин дээр пенициллин G 2x10⁶ нэгж/л, стрептомицин 200 мг/л, полимиксин В 2x10⁶ нэгж/л, гентамицин 250 мг/л, нистатин 0.5x10⁶ нэгж/л, офлоксацин HCl 60 мг/л–ийг нэмээд 1–2 мл–ийн багтаамжтай эргэдэг тагтай саванд ариутгагч шүүрээр шүүж савлана.

Дөрөв. Дээж, эмгэгт материал авах

4.1. Мал, амьтнаас дээжийг амьд юм уу үхэсний дараа авна.

4.2. **Амьд мал, амьтнаас дээж авах:** Амьд мал, амьтнаас цус, баас, шээс, сүү, нус, нулимс, цэр, хамрын болон хошноого, сүвний арчдас, арьсны хусдас, үрийн шингэн, үтрээний салс, хээлийн зулбадас, хаг, буртаг зэргээс дээж авна.

4.2.1. **Баас:** Мал амьтны шинэхэн баас эсвэл мал, амьтны хошноого, шувууны сүвнээс авна.

4.2.2. **Цус:** Гематологийн шинжилгээ, цуснаас өсгөвөр гаргах, эгэл биетэн илрүүлэх шинжилгээнд зориулан ЭДТА (этиленедиаминететраацид) гепаринтай вакутайнерын хуруу шилэнд цус авна. Ийлдэс: ийлдэс судлалын шинжилгээнд авсан цуснаас зөвхөн ийлдсийг ялган авч хүргүүлнэ.

4.2.2.1. Цуснаас түрхэц бэлтгэж болох бөгөөд түрхэцийг чихний үзүүр болон гүрээний хураагуур судаснаас, шувууныхыг далавчны хураагуур судас, залаанаас бэлтгэнэ.

4.2.2.2. Цус авах чихний үзүүрийн үсийг хяргаж эхлээд спиртээр, дараа нь эфирээр арчиж ариун зүү юм уу скальпелаар хатгана. Эхний дусал цусыг ариун хөвөнгөөр арчаад дараагийн нэг жижиг дуслыг бодисын шилэн дээр дусааж өөр бодисын шилний ирмэгээр огцом татаж түрхэнэ. Цусны түрхэц зөв хийгдсэн бол нимгэн, жигд, уртаашаа хангалттай татагдсан байх ба өргөн нь бодисын шилнийхээс бага, урт нь бодисын шилний уртаас 0,5-1 см богино байна.

4.2.2.2.1. Түрхэц бүрийг шинэ дусал цусаар бэлтгэнэ.

4.2.2.2.2. Бэлтгэсэн түрхэцийг агаарт хатаана. Галд ээх, наранд хатааж болохгүй.

4.2.2.2.3. Хүйтэн улиралд түрхэц бэлтгэхдээ дулаан байранд юм уу бодисын шилийг урьдчилан бүлээтгэх аргыг хэрэглэнэ.

4.2.2.2.4. Цусны эгэл биетэн шинжлэх түрхэцийг эхний дусал цуснаас бэлтгэнэ.

4.2.2.2.5. Түрхэцийг хатаасны дараа үзүүртэй зүйл юм уу балын харандаагаар уг мал, амьтны хувийн дугаар, хоч, бэлтгэсэн сар өдрийг тухайн бодисын шилэн дээр бичнэ.

4.2.2.3. Ийлдэс судлалын шинжилгээнд зориулж мал, амьтны хүзүүг 3 хуваасны дээд хэсгийн гүрээний судаснаас, гахайн чих, сүүлний үзүүр, нүдний судаснаас, шувууны далавчны хураагуур судас, залаанаас цус авна.

4.2.2.4. Цус авах хэсгийн үс, ноосыг хяргаж талбай бэлтгээд спиртын уусмалаар арчина. Гахайн сүүлийг савантай усаар угааж карболын хүчлийн 5%-ийн уусмалаар арчаад үзүүрийг нь хяргана.

4.2.2.5. Цусыг дусагнуулахгүй, хөөсрүүлэхгүйгээр хуруу шилний ханын дагуу авч ийлдэс ялгах цусыг дулаан газар цаг, сэрүүнд хонуулж ялгана.

4.2.2.6. Авсан цусыг 30°-35°С дулаан газар нэг цаг байлгаж бүлэгнүүлээд сэрүүн газарт 10-12 цаг болгосны дараа тунасан ийлдсийг ийлдсийн түбед ялгана. Бага тунасан, эсэл тунаагүй бол соруур, центрифуг ашиглана.

4.2.2.7. Ийлдэс нь муу ялгарсан юм уу шилний дээд хэсэгт бүлэн наалдаснаас ийлдэс нь дороо байвал нарийн төмөр утсаар (урьдчилан дөл дээр халааж ариутгаад хөргөнө) бүлэнг

хуруу шилний хананаас хөндийрүүлэх юм уу 2,500 эрг/мин аар 10–15 минут хурилдуурдаж бүлэнг доош суулгана.

4.2.2.8. Мал амьтнаас авсан цусыг авах үе дааргах, хөлдөөж болохгүй. Хөлдсөн цусны улаан эс задардаг тул ийлдэс судлалын шинжилгээнд хэрэглэхгүй.

4.2.3. **Арьс:** Арьсны гэмтэлтэй хэсгийн эпители эдийг хусах, зүсэх аргаар нэг цэгээс 1-2 грам орчим авах ба салст бүрхүүл, хэлний хучуур эдийг хуулж авна.

4.2.3.1 Арьс, салст бүрхүүл дээр үүссэн цэврүү, үлхийний шингэнийг ариун тариураар соруулж аваад цэвэр тюбед юүлнэ.

4.2.3.2 Паразит, мөөгөнцөр судлалын шинжилгээнд арьсны эпидермисийн эдээс хусаж авна.

4.2.3.3 Арьсанд үүссэн буглаа, идээ бээрээс ариун тариураар соруулж авах буюу наалдац, түрхэц бэлтгэнэ.

4.2.3.4. Арьсны гүнд эмгэг үүсгэдэг демодекоз, хулгана яр зэрэг өвчний үед арьсны гүвдрүүний оройг тариурын зүүгээр хатгах буюу хутгаар зүсээд хуруугаар болон хямсаагаар чимхэн шахаж агуулагдахууныг нь авна.

4.2.3.5. Үс, ноос, ноолуур, өд, сөдийг угаар нь хяргаж авна.

4.2.4. **Үржлийн эрхтэн:** Үржлийн эрхтнээс ариутгасан хөвөн болон самбай бойтуураар арчин арчдас авах буюу үтрээний толь ашиглан үтрээний салсыг авна.

4.2.4.1. Үнээний үтрээнээс салс авахад зориулж 10x12 см-ийн хэмжээтэй самбай авч 60–70 см урттай утсаар голоор нь уяж 40 см урт, 1–1.4 см голчтой шилэн гуурсанд утсаа сүвлэн татаж оруулна. Шилэн гуурсны 2 үзүүрийг пергаментэн цаасаар боож автоклавдаж ариутгана. Дээж авахын өмнө үнээний бэлгийн гадна эрхтнийг савантай бүлээн усаар сайтар угааж шилэн гуурсаа үтрээнд оруулан төмөр саваагаар самбайгаа түлхэж гаргаад шилэн гуурсаа сугалан авна. 30–60 минут болгосны дараа самбайгаа авч тэжээлт орчинд бохирдуулалгүйгээр хийнэ.

4.2.4.2. Зохиомол сэдээлт үүсгэн чинэрсэн чивний гадаргуу, тээрхийн хананаас хөвөн бойтуураар арчих аргаар тээрхийн салснаас авна.

4.2.4.3. Үрийн шингэнийг зохиомол үтрээ ашиглаж ариун нөхцөлд авна.

4.2.4.4. Тээрхийн салс, үрийн шингэн авах бол тээрхийд сүүлийн 30 хоногт ямар нэгэн эмийн бодис хэрэглэхийг хориглоно.

4.2.5. **Нулимс, нус:** Хөвөн буюу самбай бойтууранд шингэнийг шингээж аваад тээвэрлэх шингэнд хийж +4⁰С-д хадгалж даруй лабораторид хүргэнэ.

4.2.6. **Сүү:** Хөхний үзүүрийг ариутгагч уусмал хэрэглэлгүйгээр угааж цэвэрлээд хатаасны дараа эхний саамыг асгаад удаах саамыг ариун саванд сааж авна.

4.2.6.1. Мөн бог малын дэлэнгийн цүнхээлд хатгалт хийж дээж авч болно. Малаа бөөрөөр нь хэвтүүлж хөхний угийг спирт, йодын хандаар арчаад уг руу нь зүүгээр хатгахад цүнхээлд орсон бол зүүний үзүүр сул хөдлөх бөгөөд ариун тариураар соруулж авна.

4.2.6.2. Зах дээр худалдаалж байгаа сүүнээс дээж авахдаа сүү бүхий сав бүрээс авна.

4.2.6.3. Ийлдэс судлалд шинжлэх сүүг хөлдөөх, хөөрүүлэх, хүчтэй сэгсрэхийг хориглоно.

4.2.6.4. Нян судлалын шинжилгээнд зориулсан сүүний дээжийг хөлдөөж болно.

4.2.6.5. Бруцеллёзын сүүний цагираг урвалд дэлэнгийн үрэвсэлтэй, халуурсан, төллөөд 2 долоо хонож байгаа малын сүү тэнцэхгүй.

4.3. **Мал, амьтны хүүрнээс дээж авах:** Эмгэг бие бүтцийн задлан шинжлэгч нь хүүр задлалтыг зөв, арга зүйн дагуу хийх дадлага, чадвартай, бие бүтцийн болон эмгэг судлалын хангалттай мэдлэгтэй байвал зохино. Хүүр задлалт хийх үед эмч болон туслагч нар халдвар хамгаалалын хувцсыг бүрэн өмссөн байна.

4.3.1. Задлахааны нгийн багаж бүрэн байхын дээр мал, амьтны төрөлд тохирсон багаж, хэрэгслийг хэрэглэнэ.

4.3.2. Дээж авах сав-бүрийг туслагч урьдчилан хаягласан бай.

4.3.3. Нян, вирус судлалын шинжилгээний дээж авахдаа ариун сав, багаж хэрэглэх бөгөөд ямар нэгэн халдваргүйтгэх бодис, уусмал хэрэглэхийг хориглоно.

4.3.4. **Жижиг мал, амьтны хүүр:** Хурга, ишиг, тугал, торой, шувуу зэргийг бүтнээр нь шингэн үл нэвтрэх уут, саванд хийнэ. Гэхдээ энэхүү журмын 7.1-7.6 дэх заалтуудыг баримтлана.

4.3.5. **Эд эрхтэн:** Нян, вирус, паразит, хор, эд судлалын шинжилгээнд зориулж тунгалгийн зангилаа, цулын эрхтэн, булчин, тархины эмгэгжсэн хэсгээс хэсэглэн огтолж авна.

4.3.5.1. Шээс, цөс, шүүрдэс, салс, үений шингэн, зулбадасны ходоодны агуулхуун зэргийг ариун тариураар соруулж авах ба ариун хуруу шилэнд савлаж нягт бөглөнө.

4.3.5.2. Нягт бүтэцтэй эд, эрхтэн, хатуурсан буглаа, булдруу, зунгааралдсан нялцгай эдээс хоёр бодисын шилний завсар хавчуулж үрэх байдлаар хөдөлгөсний дараа үзүүрээс нь барьж хоёр тийш нь гулгуулан татаж хоёр бодисын шилэн дээр нимгэн наалдац үлдээх замаар наалдац бэлтгэнэ.

4.3.5.3. Эд эрхтний гадарга дээр дарж дардас бэлтгэж болохоос гадна эд эрхтнээс огтолж хямсаагаар авч бодисын шилэн дээр зөөлөн дарж наалдац бэлтгэнэ.

4.3.5.4. Мөн эрхтнийг хурц хутгаар зүсэж зүсэлтийн гадарга дээр бодисын шилээр хөнгөхөн дарж нимгэн дардас бэлтгэж болно.

4.3.6. **Чөмөгт яс:** Булуунуудыг гэмтээлгүйгээр бүтнээр авч булчин, шөрмөснөөс нь сайтар цэвэрлээд ариутгах уусмалаар норгосон даавуу буюу пергамент цаасанд бооно.

4.3.7. **Гэдэс:** Гэмтэлтэй, хувиралттай хэсгийн баасыг сэгсэрч цэвэрлээд хоёр талаар нь боож тайрна. Хүүрнээс баас явуулах бол гэдсийг доторхи баастай нь хоёр үзүүрээр нь боож авна.

4.4. **Гадаад орчин, гэжээл:** Эрүүл ахуй, ариун цэврийн хяналтын зорилгоор баас, шээсээр бохирдсон хэсэг, дэвсгэр хэвтэр орчмын гадаргуугаас арчдас авна.

4.4.1. Хүнсний зах, дэлгүүрийн лангуу, мал нядалгааны газар, зохиомол хээлтүүлэг болон мэс заслын багажийн бохирдлыг тогтоох зорилгоор арчдас авна.

4.4.2. Хөрсний халдварын үед газрын хөрсний шинжилгээнд зориулж дээж авахад шинжлэх талбайг 10–16 м² хэмжээтэйгээр хэд хэдэн хэсэг болгон хувааж хэсэг болгоны 4 булан, гол гэсэн таван цэгээс тус бүр 20–30 грам авна.

4.4.2.1. Хөрсний дээжийг нягт цаасан уутанд савлаж амсарыг битүүмжлэн наана. Полиэтилен уутанд савлаж болохгүй.

4.4.3. Гол мөрөн, нуурын уснаас дээж авахдаа дээд хэсгийн 1015 см болон ёроолоос нь тусгай тоноглон шилэн саваар 0.5 литрээс багагүйг авна.

4.4.3.1. Гоожуурын уснаас дээж авахын тулд цоргоны амсарыг спиртэн бамбараар арчиж шатаасны дараа усыг нь 10 минут гоожуулж 0.5 литрийг авна.

4.4.4. Задгай гэжээлийн 4 м² талбайн өнгөц болон гүн хэсгээс 100 грамаас дээш дээж авна. Дээжийг хэд хэдэн цэгээс авна.

4.4.4.1. Боодолтой буюу савласан гэжээлээс 10 хүртэл бол нэг бүрчлэн, 11–100 бол 10 тутмаас нэг, 100–гаас дээш бол 10 тутмаас нэг, нэмэлт болгож 100 тутмаас 3 дээж авна. Дээжийн хэмжээ 100 грам байна.

4.4.4.2. Нуруулдсан өвсний 4 м² талбайгаас 40 грамаас багагүйг авна.

4.4.4.3. Үндэс үртэн ургамлаас дээж авахдаа 4 м² талбайгаас 1–3 ширхэгийг авна.

4.5. **Зөгий:** Үхсэн буюу түүний зэргэлдээх сархиагны бие гүйцсэн зөгийг түүвэрлэх ба амьд боловч өвчний сэжигтэй зөгийг түүн хөлдөөж үхүүлээд шилэн саванд хийж +4⁰С-д хадгалж лабораторид хүргэнэ. Сархиаг бүрээс авсан зөгийг тус тусад нь савлана. Савны гадна бүл, үүр, сархиагны дугаарыг бичнэ.

4.6. **Эд судлалын шинжилгээнд материал авах** Эмгэг эд судлалын шинжилгээний материалыг шинэхэн хүүрнээс буюу нядалсан малын эмгэг хувиралт бүхий эрхтэн, эдүүдээс авна.

4.6.1. Эд эрхтний янз бүрийн хэсгээс нимгэхэн, жижиг зүсэм байдалтай огтлон авах ба зузаан нь 1–2 см-ээс илүүгүй, эргэн тойрны гэмтээгүй хэсгийг оролцуулж авна.

4.6.2. Тухайн эрхтэн, эдийн бүтцийг харгалзан зүсэж авна. Жишээлбэл бөөрний зүсмийг авахдаа холтослог, тархилаг давхаргын аль алиныг оролцуулсан байна. Нэгэн жигд бүтэцтэй эрхтнээс түүний бүрээсийг оролцуулж авна.

4.6.3. Эд, эрхтнийг зүсэж авмагц бэхжүүлэгч шингэнд хийх ба зүсмийн эзэлхүүнээс 10 дахин их байвал зохино.

4.6.4. Бэхжүүлэгч шингэнийг нэг хонуулаад шинэчилж солих ба заавал шилэн саванд бэхжүүлнэ.

4.6.5. Тархи, нугас болон мэдрэлийн бусад эдийг 10%-ийн саармаг формалинд бэхжүүлэх нь илүү тохиромжтой.

4.6.6. Эрхтэн, эд агуулсан сав дээр уг мал, амьтны төрөл, хувийн дугаар буюу хоч, эд эрхтний нэрийг бичнэ.

4.6.7. Нэг мал, амьтнаас авсан дээжүүдийг тус тусын хаягтайгаар самбайд боож нэг саванд хийн илгээж болно.

Тав. Халдварт, паразиттах өвчний онцлогт тохируулан эмгэгт материалын дээж авах

5.1. Төрөл бүрийн мал, амьтны өвчин

5.1.1. **Шүлхий.** Үүсгэгчийг илрүүлэх шинжилгээнд зориулж өвчилсөн 2-оос цөөнгүй мал, амьтны хэд хэдэн хагарсан юм уу хагараагүй үлхийн хучуур эдийг 1 г–аас багагүй, хэлний хуурсан хучуур эд 5 грамаас багагүй хэмжээтэй авч илгээнэ. Ихэвчлэн хэл, амны хөндийн салст бүрхүүл, хөлнөөс авна. Үлхий нь илжирч зөөлрөөгүй, өмхий үнэргүй байвал зохино.

5.1.1.1. Хагараагүй үлхийн шингэнийг ариун тариураар соруулж авахын дээр үүссэн шархлааны хэсгээс огтолж авна.

5.1.1.2. Шүлхийн өвөрмөц эсрэгбием илрүүлэх ЭЛИЗА урвалд зориулж өвчний эмнэл зүйн шинж тэмдэг илрээд 5–аас дээш хоносон болон эдгэрсэн хэд хэдэн малаас цус авна. Мөн вакцинжуулалтын үр дүн тогтоох, шүлхийн вирусээр урьд халдварласан эсэхийг тодорхойлох зорилгоор цусны хос дээж авч болно.

5.1.1.3. Өвчний шинж тэмдэг илрээгүй юм уу өвчлөөд эдгэрсэн мал, амьтнаас залгиурын салсны дээж (пробанг) авна.

5.1.1.4. Гахайнаас цус, залгиурын арчдас, хагарсан юм уу хагараагүй үлхийн хучуур эдийг авна. Зэрлэг амьтадад шүлхийн халдвар байгаа эсэхийг тандах зорилгоор цус, залгиурын салс авч болно.

5.1.2. **Үхрийн мялзан** өвчний эхний үед халуунтай үхрээс ЭДТА–тай юм уу гепаринтай цус, амны шархны хэсэг, нулимснаас дээж авна.

5.1.2.1. Үхсний дараа уушиг, дэлүү, тунгалгийн зангилаа, ЭДТА–тай хуруу шилэнд цус авна. Мялзангийн эсрэгбие илрүүлэх ЭЛИЗА урвалд зориулж эдгэрсэн малаас цусны ийлдэс (ийлдсийн хос дээж байх нь илүү ач холбогдолтой) авна.

5.1.2.2. Эмгэг эд судлалын шинжилгээнд тунгалгийн зангилаа, дэлүү, гүйлсэн булчирхай, тэжээл боловсруулах, шээс, бэлэг, амьсгалын замын эд эрхтнээс авна.

5.1.3. **Хэл хөхрөх** өвчний үед халуунтай, өвчний шинж тэмдэг илэрсэн малаас ЭДТА юм уу гепаринтай хуруу шилэнд цус авч хүргүүлнэ.

5.1.3.1. Үхсэн мал, амьтнаас дэлүү, тунгалгийн зангилаанаас дээж авч +4⁰Сд хадгалж хүргүүлнэ.

5.1.3.2. НГУ, ЭЛИЗА урвалд зориулж цусны ийлдэс илгээнэ.

5.1.4. **Амны цэврүүт үрэвслийн** үед цэврүүний шингэн, хучуур эд, залгиурын салс, арчдас болон цусны дээж авч хүргүүлнэ.

5.1.4.1. Дээжийг фенол улаан бүхий трис буферын триптоз шөлөнд (рН 7.6) хийж болохын дээр хөлдөөж 48 цагийн дотор лабораторид хүргүүлнэ.

5.1.4.2. Вирус саармагжуулах урвал, ЭЛИЗА урвалд зориулж цусны ийлдэс илгээнэ.

- 5.1.5. **Галзуу** өвчний шинжилгээнд жижиг амьтны толгой, том амьтны тархийг хадгалааслахгүйгээр шинээр нь буюу глицерины 30-50%-ийн уусмалд хадгалаасласан байдлаар хүргүүлнэ.
- 5.1.6. **Ауескийн** өвчний вирус өсгөвөрлөх болон амин сорилын шинжилгээнд зориулж амьд гахайнаас хамрын гоождос, залгиурын арчдас, багалзуур, залгиурын шингэн авна.
- 5.1.6.1. Үхсэн гахайнаас бүтэн тархи юм уу уртавтар тархи, нугасны шингэн ба дэлүү, элэг, уушигны хэсгийг илгээнэ.
- 5.1.6.2. Ийлдэс судлалын шинжилгээнд зориулж цус авч явуулна.
- 5.1.7. **Баруун Нилийн** өвчний үед үхсэн адууны тархи, нугас, шувууны тархи, элэг, зүрхний хэсгээс дээж авна.
- 5.1.7.1. Ийлдэс судлалын шинжилгээнд цусны ийлдэс явуулна.
- 5.1.8. **Ку-халууралын** үед шинжилгээнд гэмтэлтэй уушиг, дэлүү, зулбадас, хаг, савны буртаг, түүнчлэн сүү, баас, цусыг илгээнэ.
- 5.1.9. **Боом** өвчний сэжигтэй үхсэн малын хүүрийг задлах хориотой. Шаардлагатай тохиолдолд бэлтгэл (хайрагч, уяа, халдваргүйжүүлэх бодис) ханган халдвар хамгааллын дэгийг сайтар мөрдөж доорх дээжийг авна.
- 5.1.9.1. Хүүрний чихний ирмэгийг зүсэж гарсан цусыг лабораторид илгээнэ.
- 5.1.9.2. Зүсэж авах хэсгийг урьдаар сайтар халдваргүйжүүлсний дараа ариутгасан хайчаар (хутга) чихний ирмэгийг зүсэж цусыг бодисын шил дээр зузаан түрхэж аваад чихний шархыг халуун төмрөөр хайрна. Бодисын шилэнд түрхсэн цусыг цэвэр нөхцөлд агаарт хатаах ба бэхжүүлэлт хийхгүй.
- 5.1.9.3. Хэрэв хүүр задалж байх үед боомын сэжиг илэрвэл задлалтыг зогсоож дэлүү, чихийг нь шинжилгээнд авна.
- 5.1.9.4. Хүүрний доод талын чихийг авах ба урьдаар чихний угаар хоёр чанга боогоод хоорондуур нь огтолно. Материал авсны дараа чихний шархыг халуун төмрөөр хайрах юм уу галаар шарна.
- 5.1.9.5. Гахайн боом өвчний сэжиг голдуу хүзүү орчимд хавдар үүссэн байдлаар илэрдэг бөгөөд хүүрийг задалж байх үед ийм шинж илэрвэл задлалтыг зогсоож нян судлалын шинжилгээнд хавантай холбогч эд, залгиурын арын тунгалгийн зангилааг авна.
- 5.1.9.6. Арьс ширэнд асколын тундасжуулах урвалын шинжилгээ хийхэд зориулж год болон цус харвасан болон хар хүрэн өнгөтэй болсон хэсгээс 5x5 см хэмжээний зүсмийг авч илгээнэ.
- 5.1.9.7. Үхсэн мал, амьтан байсан болон үхсэн мал, амьтны сүвнээс гоожсон цус, шингэнээр бохирдсон хөрсний дээжийг лабораторид явуулж болно.
- 5.1.9.8. Ноос, ноолуур, үсхялгаснаас дээж авахад ноосны бохирдолтой хэсгээс хэд хэдэн дээж авна. Баглаатай ноос, ноолуур, үс, хялгасны янз бүрийн хэсэг болон оёдлын дагуу хуримтлагдсан тоос, шорооноос 3 г-аас багагүй хэмжээтэйгээр 5–аас доошгүй дээж авна.
- 5.1.10. **Дэлэнгийн үрэвслийн** үед өвчтэй малын гэмтэлтэй дэлэнгээс сүүний 3 хэсэг дээж (саамын эхний, дунд үеийн, хамгийн сүүлчийн сүүг) тус бүр 2 мл-ээс багагүй хэмжээгээр авна.
- 5.1.10.1. Дэлэнд буглаа үүссэн бол түүнээс тариураар соруулж аваад илгээнэ.
- 5.1.10.2. Үхсэн малаас дэлэнгийн болон уушигны тунгалгийн зангилаа, гэдэс дотор, элэг, үе мөч, цээжний хөндийд үүссэн буглаа зэргийг авч илгээнэ.
- 5.1.11. **Некробактериоз (балцруу, сөдрөг)** өвчний үед амьд мал, амьтны хөл туурайн арьсны болон амны хөндийн салст бүрхүүлийн шархнаас, тэдгээрийн шүүрдэсээс авна. Үхсэн ба нядалсан амьтны дотор эрхтний үхжсэн эд, ялангуяа элэг заавал авна.
- 5.1.11.1 Гэмтэлтэй эрхтэн, эдийн үхжсэн хэсгийг эрүүл эдээс оролцуулан зүсэж авна.
- 5.1.12. **Зогсоогийн** нян судлалын шинжилгээнд шархны гүн хэсгийн ёроолын эдийн зүсэм, шархны гоождосыг илгээнэ.
- 5.1.13. **Ботулизмын** үед нян судлал, амин сорилын шинжилгээнд ходоодны агуулагдахуун 100–200 мл, элэг, цуллагийн эрхтнүүдийн хэсгийг авна. Эмгэгт дээжийг хадгалааслаж болохгүй.
- 5.1.13.1. Өвчтэй малаас ЭДТА юм уу гепарин бүхий хуруу шилэнд цус авна.

5.1.13.2. Сэжиг бүхий тэжээлийн (дарш, хүчит тэжээл, хивэг, махны болон загасны хаягдал гэх мэт) янз бүрийн хэсгээс нь хэд хэдэн дээж авна. Дээжийн хэмжээ 100 г-аас багагүй байна. Тэжээлийн дээжийг гэрэл нэвтрэхгүй уутанд хийж илгээх ба хатахаас хамгаална.

5.1.14. **Сүрьеэ** өвчний үед нян судлалын шинжилгээнд уушигны сүрьеэгийн сэжигтэй малын цагаан хоолойн цэрийг ариун хөвөн бойтуураар (төмөр утсанд бэхэлсэн) авна.

5.1.14.1. Дэлэнгийн сүрьеэгийн сэжигтэй малаас сүүний дээж авах ба гараа сайтар угааж спиртээр арчиж халдваргүйжүүлнэ.

5.1.14.2. Дэлэнг угааж 70%-ийн спиртээр халдваргүйжүүлсний дараа сүүний эхний, дунд, сүүлчийн хэсгүүдээс нийтдээ 150-200 мл дээж сааж авна.

5.1.14.3. Малын хүүр, нядалсан малаас нян судлалын шинжилгээнд гэмтэл үүссэн эрхтний бүрээсжээгүй, хатуурч шохойжоогүй булдруутай хэсгийг илгээнэ.

5.1.14.4. Эд судлалын шинжилгээнд гэмтэлтэй эрхтэн, чацархайн болон тунгалгийн зангилгааны хэсгийг илгээнэ.

5.1.14.5. Ийлдэс судлалын шинжилгээнд цусны ийлдэс илгээнэ.

5.1.15. **Иж сүрьеэгийн** нян судлалын шинжилгээнд зориулж бааснаас бөөнтсөн салс, цусархаг залхаг, гэдэсний салст бүрхүүлийн тасархай зэргийг ялган авна.

5.1.15.1. Өвчний сэжигтэй малын (чацга алдсан) шулуун гэдэсний салст бүрхүүлийн хусдас авч лабораторид хүргүүлж болно.

5.1.15.2. Малын хүүр болон нядалсан малаас гэдэсний гэмтэлтэй хэсэг, гэмтэж өөрчлөгдсөн чацархайн тунгалгийн зангилгааг илгээнэ.

5.1.15.3. Эд судлалын шинжилгээнд дээрхийн адил материалыг формалины 10%-ийн буфержүүлсэн уусмалд хадгалааслан хүргүүлнэ.

5.1.15.4. Ийлдэс судлалын шинжилгээнд цусны ийлдэс илгээнэ.

5.1.16. **Бруцеллёзын** шинжилгээнд цус, ийлдэс, сүүний дээж авна. Нян судлалд ХХУ-аар эерэг гарсан малаас сүү, үтрээний арчдасын дээж авна.

5.1.16.1. Шаардлагатай тохиолдолд хээл хаясан малын зулбадсыг бүтнээр, хагийг нь буюу хээлийн ходоодыг улаан хоолой, нарийн гэдэсний үзүүр талаас боож доторх шингэнтэй нь, цуллагийн эрхтний хамт явуулах ба халдвар авах, тараах эрсдэлтэй тул аль болох болгоомжлох нь чухал.

5.1.16.2. Мөн шөрмөсний уутын үрэвслийн болон буглааны шингэн, үтрээний салс, дэлэнгийн хэлтэн бүрээс саасан 15 мл-ээс багагүй сүүг шинжлүүлж болно.

5.1.16.3. Нядалсан малын цуллагийн болон үржлийн эрхтэн, цавь, дэлэнгийн ар, гол судас хажуугийн, ходоодны доод, өлөн хонхор, гуя, далны урд, багалзуур, чацархайн тунгалгийн зангилаа болон хос булчирхайг хоёуланг авна.

5.1.17. **Кампилобактериозын** нян судлалын шинжилгээнд зориулж үнээ болон эм хонины хээл (зулбадас), хагийг нь түүнчлэн ариун нөхцөлд авсан умайн хүзүүвчний салс, бух, хуцны чивний шамархайн салс, үрийн шингэнийг ариун нөхцөлд авна.

5.1.17.1. Мөн нядалсан малын үтрээ, сав, аарцгийн хөндийн тунгалгийн зангилаа, бэлгийн дайвар булчирхайнуудыг авч болно.

5.1.17.2. ЭЛИЗА, наалдуулах урвалын шинжилгээнд зориулж цус, үтрээний салс авна.

5.1.17.3. Эмгэгт материалыг хөлдөөгч гель бүхий сав юм уу хөргөгчид хийж лабораторид хүргэнэ.

5.1.17.4. Малын хээлийг хээл хаяснаас хойш 10–12 цагийн дотор хүргэвэл шинжилгээнд тэнцэнэ.

5.1.17.5. Хөлдүү бол хээл хаяснаас хойш 2 хоногоос хэтрүүлэлгүй хүргэнэ.

5.1.17.6. Үрийн шингэн, чивний шамархай буюу үтрээний салс, зайлдас зэргийг авмагц хөлдөөгч гель бүхий сав юм уу хөргөгчид хийж 6 цагийн дотор лабораторид хүргэнэ.

5.1.18. **Лептоспирозын** нян судлалын шинжилгээнд сүү, цус, нугасны шингэн, шээсийг хадгалааслалгүйгээр шинээр нь лабораторид илгээнэ.

5.1.18.1. Эмгэг эд судлалын аргаар лептоспир илрүүлэх шинжилгээнд үхсэн малын элэг, бөөр, зүрхний булчин, тунгалгийн зангилгааг авна.

- 5.1.18.2. Мал, амьтан үхсэнээс хойш юмуу нядалсаны дараа 2 цагийн дотор эмгэгт материалаас шинжлэгдэхүүн авангуут лептоспирийг өсгөвөрлөх тэжээлт орчинд шууд тарих нь амьд өсгөвөр гаргах боломжийг нэмэгдүүлнэ.
- 5.1.18.3. Пироплазмозоос ялган оношлох зорилгоор өвчтэй малын чихний цусны түрхэцийг илгээнэ.
- 5.1.18.4. Ийлдэс судлалын шинжилгээнд цус буюу ийлдэс илгээнэ.
- 5.1.19. **Листериазын** үед нян судлалын болон амин сорилын шинжилгээнд торойн шинэ бүтэн хүүр юм уу цуллагийн эрхтнүүд, толгойг нь авч явуулна.
- 5.1.19.1. Бод, бог малын тархи юм уу толгой, цуллагийн эрхтэн нэг бүрээс хэсэгчлэн авна.
- 5.1.19.2. Гэмтэлтэй ч, гэмтэлгүй ч дэлэнгийн хэлтэн тус бүрээс сүүг 10 мл-ээс багагүйг авна.
- 5.1.19.3. Ийлдэс судлалын шинжилгээнд цус буюу ийлдэс илгээнэ.
- 5.1.19.4. Хээл хаясан малын зулбадас, хаг, буртагийг илгээнэ.
- 5.1.20. **Цусан халдвар** өвчний үед нян судлалын шинжилгээнд өндөр халуунтай байгаа өвчтэй малаас цус авч хүргүүлж болно.
- 5.1.20.1. Хүүрний зүрхний цус, цуллагийн эрхтнүүдийн хэсэг, ялангуяа уушиг ба чөмөгт яс болон шувуу, туулай зэрэг жижиг амьтны хүүрийг бүтнээр нь илгээнэ.
- 5.1.20.2. Гэдэсний хэлбэрээр өвчилсөн малын гэдэсний гэмтэлтэй хэсэг, бааснаас авч илгээж болно.
- 5.1.21. **Хуурамч сүрьеэ** өвчний үед нян судлалын шинжилгээнд гэмтэлтэй эрхтүүдийн ирээрт буглааг хагалалгүйгээр бүтнээр авах ба томорсон тунгалгийн зангилааг илгээнэ.
- 5.1.21.1. Ийлдэс судлалын шинжилгээнд цусны ийлдэс авна.
- 5.1.21.2. Жижиг амьтны хүүрийг бүтнээр илгээж болно.
- 5.1.22. **Туляреми** өвчний үед нян судлалын шинжилгээнд үхээд удаагүй мал, амьтны элэг, дэлүү, чөмөгний хэсэг, томорсон тунгалгийн зангилааг глицерины уусмалд хадгалаасласан байдлаар эсвэл эд эрхтнээс шинжлэгдэхүүн авангуут туляреми өсгөвөрлөх орчинд тарьж илгээнэ. (Үхсэн мал, хүүрнээс үүсгэгчийг илрүүлэх амаргүй байдаг.)
- 5.1.22.1. Эд судлалын шинжилгээний дээжийг формалинд бэхжүүлж илгээнэ.
- 5.1.22.2. Жижиг амьтны хүүрийг бүтнээр илгээнэ.
- 5.1.22.3. Ийлдэс судлалын шинжилгээнд цусны ийлдэс явуулна.
- 5.1.23. **Иж балнад** өвчний үед нян судлалын шинжилгээнд жижиг амьтны хүүрийг бүтнээр буюу цуллагийн эрхтнүүдийн хэсэг (элэгний хэсгийг цөсний уутын хамтаар, тунгалгийн зангилаа, дэлүү, бөөр) чацархайн тунгалгийн зангилаа, чөмөгт яс, мал хээл хаясан тохиолдолд зулбадсыг хагны хамт илгээнэ.
- 5.1.23.1. Нян тээгчийг илрүүлэх зорилгоор цусны ийлдсийг илгээнэ.
- 5.1.23.2. Баасны дээж авахдаа бааж дууссны дараа сүүлчийн хэсгээс нь авах ба цус, залхаг салс, идээ бээр гарвал тэдгээрийг дээжинд хамруулна.
- 5.1.23.3. Баасны дээжийг лабораторид шуурхай хүргэх бололцоогүй бол глицерины уусмал болон фосфатын буферын уусмалд хадгалааслаж илгээнэ.
- 5.1.24. **Колибактериазын** үед төлийн бүтэн, шинэ хүүр буюу зүрх, цуллагийн эрхтнүүд, чөмөгт яс, толгой, чацархайн тунгалгийн зангилгаа зэргийг илгээнэ.
- 5.1.24.1. Өвчтэй төлийн шулуун гэдэсний баасыг авч илгээж болно.
- 5.1.24.2. Шувууны колибактериазын үед өвчилсөн шувууг амьдаар хүргүүлнэ.
- 5.1.25. **Стрептококкийн халдварын** (*Streptococcus pneumoniae*) үед нян судлалын шинжилгээнд шинэ хүүр буюу зүрхний цус, дэлүү, элэг, тунгалгийн зангилаа, гэмтэлтэй үе мөч, чөмөгт яс, тархи зэргийг илгээнэ.
- 5.1.25.1. Үнээ, хонь, мэгжний савны үрэвслийн үед ариун бойтуураар авсан үтрээний гоождос, дэлэнгийн үрэвслийн үед сүү илгээнэ.
- 5.1.25.2. Хүйтний улиралд эмгэгт материалыг хөлдүү байдлаар илгээж болно. Диплококк 16°C-20°C-ын дулаанд 24-30 цагийн дотор үхдэг.
- 5.1.26. **Лейшмениозын** үед дурандах шинжилгээнд чөмөг, тунгалгийн зангилаанууд, дэлүү, элэгнээс авахын зэрэгцээ эдгээр эдээс түрхэц бэлтгэж явуулна.

- 5.1.26.1. Арьс гэмтсэн бол түрхэц бэлтгэж хүргүүлнэ. Арьс гэмтээгүй бол дэлүүнд хатгалт хийж түрхэц бэлтгэнэ.
- 5.1.26.2. Иммунологийн шинжилгээнд зориулж цус авч явуулна.
- 5.1.27. **Бэтэг** өвчний үед мал амьтны эхинококкийн авгалдайн цист үүссэн эд, эрхтэн ялангуяа эмгэгтсэн элэг, уушгийг шинжилгээнд явуулна.
- 5.1.28. **Трихинеллёзын** үед өрц, хэл, зажуурын булчингаас 100 г–аас багагүй хэмжээтэй авна.
- 5.1.28.1. ЭЛИЗА урвалд зориулж мал нядлахын өмнө юм уу нядласны дараа цус, ийлдэс, эдийн шингэн, махны шүүсийг авна.

5.2 Адууны өвчин

- 5.2.1. **Ям** өвчний ЭЛИЗА, ХХУ-ын шинжилгээнд ям өвчний сэжигтэй малын цус, ~~нууны~~ ийлдэс, хамрын арчдасны дээж авч илгээнэ.
- 5.2.1.1. Нян судлалын шинжилгээнд хүүрний буюу нядалсан адууны гэмтэлтэй арьс, хамрын хөндийн үрэвсэлтэй хэсэг, уушиг болон бусад эрхтний хэсэг ба тунгалгийн зангилгааг сонгож авах ба халдвар хамгааллыг сайтар мөрдөх. .
- 5.2.1.2. Эмгэг эд судлалын шинжилгээнд хүүрний буюу нядалсан адууны гэмтэлтэй арьс, хамрын хөндий, уушиг болон бусад эрхтний хэсэг ба тунгалгийн зангилгааг формалины 10%-ийн буфержүүлсэн уусмалд хадгалаасалж илгээнэ.
- 5.2.2. **Адууны халдварт цус багасах өвчний** үед эмгэг эд судлалын шинжилгээнд элэг, дэлүү, уушиг, бөөр, зүрхнээс 2x2 см хэмжээний зүсэм авч 10% формалинд хадгалаасан илгээнэ.
- 5.2.2.1 Цус судлалын шинжилгээнд ЭДТА юм уу гепаринаар тогтворжуулсан цус ба цусны цагаан цогцсын хэмжээг тодорхойлох зорилгоор цусны түрхэц илгээнэ.
- 5.2.2.2. Ийлдэс судлалын шинжилгээнд цус авч явуулна.
- 5.2.3. **Япон энцефалитийн** үед тархины аммони эвэр, өнчин тархи, дөрвөн товгор, уртавтар тархи болон нугасны шингэн, цус илгээнэ.
- 5.2.3.1. Дээжийг шинэ хүүрнээс авах ба авсан даруйд хөлдөөх юм уу 48 цагаас дээш хадгалах бол –80°С–д хөлдөөнө.
- 5.2.3.2. Хүн өвчлөх аюултай учир задлан шинжлэгч нь биоаюулгүй ажиллагааны нөхцөлийг хангасаны дараа хүүрийн задалгаа үйлдэх ба ажиллах эмч урьдчилан сэргийлэх вакцин тариулсан байна.
- 5.2.4. **Адууны энцефаломиелит** өвчний үед вирус илрүүлэх болон эмгэг эд судлалын шинжилгээнд зориулж тархи, дэлүү, элэгнээс дээж авч хүргүүлнэ.
- 5.2.4.1. Ийлдэс судлалын шинжилгээнд цусны ийлдэс бэлтгэж явуулна.
- 5.2.5. **Адууны томуу** өвчний үед өвчтэй адууны хамрын хөндийн арчдасыг тээвэрлэх орчинд хийж хүргүүлэх ба хүүрнээс уушиг, цагаан хоолой буюу уушигны гуурсны шингэнийг илгээнэ.
- 5.2.5.1. Өвчлөөд эдгэрсэн адууны цусны ийлдэсний хос дээж хүргүүлнэ.
- 5.2.6. **Гүүний халдварт метрит** өвчний үед гүүний үтрээний гоождос, эсвэл үтрээний арчдас (арчдас авах бол 7 хоногийн өмнөөс антибиотикийн эмчилгээг зогсооно) авч лабораторид 48 цагийн дотор хүргэнэ.
- 5.2.6.1. Дээжийг нэг азраганы хэд хэдэн гүүнээс, эсвэл бүх гүүнээс авна.
- 5.2.6.2. Тээгч гүүг илрүүлэх зорилгоор цусны ийлдэс авч хүргүүлнэ.
- 5.2.7. **Хулгана яр** өвчний үед хагараагүй идээт гүвдрүүнүүдээс тариураар бээрийг соруулж авна.
- 5.2.7.1. Хагарсан гүвдрүүнүүдийг угаар нь шахаад бээрийг авч болно.
- 5.2.8. **Адууны ринопневмони** өвчний үед хамар багалзуурын болон үтрээний арчдасыг тээвэрлэх орчинд хийж хөргөгчид байлган хөлдөөлгүй хүргүүлнэ.
- 5.2.8.1. Гүүний зулбадаснаас элэг, уушиг, дэлүү, сэрээ булчирхайнаас дээж авч илгээнэ.
- 5.2.8.2. Үхсэн адуунаас тархи, уушиг зэрэг цуллагийн эрхтний дээжийг хүргүүлэх ба эмгэг эд судлалын шинжилгээний дээж авна.
- 5.2.8.3. Ийлдэс судлалын шинжилгээнд цусны ийлдэс бэлтгэж явуулна.

- 5.2.9. **Адууны вирусын артерит** өвчний шинжилгээнд амьд адуунаас халуурч байх үед нь хамар, залгиурын болон нүдний арчдас, бүлэгнээгүй цус, азраганы үр авах хэрэгтэй .
- 5.2.9.1. Гүү хээл хаясан тохиолдолд эхсийн шингэн, эхэс, зулбадасны уушгийг авна.
- 5.2.9.2. Ийлдэс судлалын шинжилгээнд цусны ийлдэс бэлтгэж явуулна.
- 5.2.9.3. Үхсэн адуунаас эмгэг эд судлалд зориулж умс, хятай, уушиг, элэг, дэлүү, тунгалгийн зангилаа, нойр булчирхайг авна.
- 5.2.10. **Сахуу** өвчний үед шинжилгээнд тунгалгийн зангилгааны хагараагүй буглааны оройн хэсгийн талбайг халдваргүйтгээд идээ бээрийг ариун тариураар соруулна.
- 5.2.10.1. Ариутгасан физиологийн уусмалаар норгосон хөвөн бойтуураар хамрын хөндийн нус ба хагарсан буглааны гэрийн доторх идээ бээрийг авна.
- 5.2.10.2. Хүүрнээс толгой, зүрхний цус, дэлүү, уушиг, гэмтэлтэй бусад эрхтний хэсгийг илгээнэ.

5.3 Үхрийн өвчин

- 5.3.1. **Үхрийн энзоот лейкозын** үед хавдрын шинж бүхий эмгэг үүссэн эрхтнүүдээс тунгалгийн зангилаа, чацархайн булчирхай, элэг, дэлүү, бөөр, ходоод, савнаас дээжлэн авна.
- 5.3.1.1. ПГУ, Цус судлалын шинжилгээнд ЭДТА юм уу гепаринаар тогтворжуулсан цус ба цусны цагаан цогцсын хэмжээг тодорхойлох зорилгоор цусны түрхэц илгээнэ.
- 5.3.1.2. Ийлдэс судлалын шинжилгээнд зориулж цусны ийлдэс хүргүүлнэ.
- 5.3.1.3. Эмгэг эд судлалын шинжилгээнд тунгалгийн зангилаа, чацархайн булчирхай, элэг, дэлүү, бөөр илгээнэ.
- 5.3.2. **Үхрийн чээж** өвчний үед ийлдэс судлалын шинжилгээнд цусны ийлдэс илгээнэ.
- 5.3.2.1. Чээжний хөндийн шингэн ба уушигны гэмтэлтэй хэсэг, тунгалгийн зангилаа, үений шингэн зэргийг авч илгээнэ.
- 5.3.2.2. Эмгэг эд судлалын шинжилгээнд уушигны эмгэгжсэн хувиралт бүхий хэсгийг формалинд хадгалааслаж хүргүүлнэ.
- 5.3.2.3. Амьд үхрээс хамрын гоождос, арчдас, мөгөөрсөн хоолойн угаасан шингэн, чээжний гялтанд хатгалт хийж авсан шингэн, цус авч хүргүүлнэ.
- 5.3.3. **Дуут хавдар, хорт хаван** өвчний нян судлалын шинжилгээнд өвчтэй мал, амьтны үрэвсэж хавдсан хэсгийн арьсан дорх нэвчдэс шингэнийг пастерийн гуурс юм уу тариураар соруулж авна.
- 5.3.3.1. Дуут хавдар, хорт хавангийн сэжигтэй үхсэн мал, амьтны хүүрийг задлахгүй байхыг хийчээх ба санамсаргүй задалсан бол элэг, дэлүү, бөөр, гэмтэлтэй булчингийн хэсгүүдийг авч илгээнэ.
- 5.3.4. **Үхрийн тархи сархиатах эмгэг** өвчний үед өвчний сэжигтэй үхрийг нядласны дараа тархийг стандарт аргаар авна.
- 5.3.4.1. Эмгэг эд судлалын шинжилгээнд уртавтар тархины дундаас хажуугийн хөндлөн ховил хүртэлх хэсгээс няцлалгүй авч формальдегидын 4%-ийн уусмалд хадгалааслах ба 5-аас цөөнгүй хоног бэхжүүлээд шинжилнэ.
- 5.3.5. **Үхрийн вирусын диарейн** үед хамраас гоожсон шингэн, хамрын хөндийн арчдас, цус, баасны салс авна.
- 5.3.5.1. Үхсэн буюу нядалсан малын хамрын хөндийн таславч, мөгөөрсөн хоолой, уушигны гэмтэлтэй хэсэг, дэлүү, тунгалгийн зангилаанууд, нарийн гэдэсний янз бүрийн хэсэг, архаг явцтай үед гэдэсний янз бүрийн хэсэг, тунгалгийн зангилаануудыг сонгон авна.
- 5.3.5.1. Ийлдэс судлалын шинжилгээнд цусны ийлдэс явуулна.
- 5.3.6. **Үхрийн ринотрахеитын** халдварын эхний үед 5–10 үхрийн хамрын гоождос, арчдас, үржлийн эрхтний үрэвслийн үед сав, үтрээ, тээрхийн арчдас авна.
- 5.3.6.1. Үхсэн үед амьсгалын замын салст бүрхүүл, залгиур, уушиг, мөгөөрсөн хоолойн тунгалгийн зангилаа, хээлийн элэг, уушиг, дэлүү, бөөр, хагны товч зэргийг авч хөлдөөлгүй хөргөөд (+2°C - +4°C) аль болох түргэн хүргүүлнэ.
- 5.3.6.2. Ийлдэс судлалын шинжилгээнд цусны ийлдэс явуулна.

5.3.7. **Хорт салст халуурал өвчний** үед эмгэг эд судлалын шинжилгээнд тунгалгийн зангилаа, дэлүү болон бусад эмгэгжсэн эрхтнүүдээс дээж авна.

5.3.7.1. Вирус судлалын шинжилгээнд бүлэгнүүлээгүй цусны цагаан эс, тунгалгийн зангилаа, дэлүү, тархи, гэдэсний гэмтэлтэй хэсгийг илгээнэ.

5.3.7.2. Ийлдэс судлалын шинжилгээнд цусны ийлдэс хүргүүлнэ.

5.3.8 **Цахлай, дерматофилёз** өвчний үед эмчилгээ хийгдээгүй амьтны арьсны гэмтэлтэй хэсгийн хусдас хайрс, хогжруу тав, хайрсны дорх шүүрдэс, үсийг авна.

5.4. Хонь, ямааны өвчин

5.4.1. **Хонины энзоот зулбахын** үед хээл, хаг, хээлийн цуллагийн эрхтний хувиралттай хэсэг ба малын бургтийг авахаас гадна ийлдэс судлалын шинжилгээнд өвчтэй малын цус, ийлдсийг илгээнэ.

5.4.2. **Шөвөг яр (амруу)** өвчний үед арьс, салст бүрхүүл дээр гарсан цэврүүний шингэн, түүний хальс, хатсан тав, шархны үхжсэн хэсгээс илгээнэ.

5.4.3. **Хонины эпидидимитын** үед үрийн шингэн, үтрээний арчдас, сүү авна.

5.4.4. Хүүрнээс хувиралттай төмсөг, эм хонины савны салс, шингэн, савны эврийн үхжсэн хэсэг, өндгөвч, аарцгийн тунгалгийн зангилгаанууд болон хээлийг илгээнэ.

5.4.4.1. Ийлдэс судлалын шинжилгээнд цус буюу ийлдсийг илгээнэ.

5.4.5 **Хонь, ямааны цэцэг** өвчний үед амьд малаас гэмтэлтэй арьсны гүвдрүүт хэсэг, гүвдрүүний шүүрдэс, хусдас, хатсан тавыг, үхсэн буюу нядалсан малаас арьсны гүвдрүүт хэсэг, уушиг, тунгалгийн зангилаанаас авч хүргүүлнэ.

5.4.5.1. ФТА шингээгч цаасанд шингээж хатаасан цус, ЭДТА эсвэл гепарин бүхий хуруу шилэнд цус авна.

5.4.5.2. Эмгэг эд судлалд зориулж формалинд хадгалаасласан уушиг, гэмтэлтэй арьсны хэсгийг явуулна.

5.4.5.3. Вирус саармагжуулах урвалд зориулж өвчтэй хонь, ямаанаас цус авч ийлдсийг ялгаж хүргүүлнэ.

5.4.6. **Аденоматоз, Маеди висна** өвчний үед хоёроос цөөнгүй амьд хонь, ямааны хамраас гарсан шингэн, бүлэгнүүлээгүй авсан цус, сүү авч хүргүүлнэ.

5.4.6.1. Үхсэн болон нядалсан малаас гэмтэлтэй уушиг, уушиг орчмын тунгалгийн зангилаа, тархи, үений шингэн, дэлэнгийн булчирхай зэргийг авна.

5.4.6.2. Ийлдэс судлалын шинжилгээнд зориулж цусны ийлдэс илгээнэ.

5.4.7. **Ямааны годронгийн** үед уушиг, цээжний хөндийн шингэн, тунгалгийн зангилаа илгээнэ.

5.4.7.1. Эмгэг эд судлалд зориулж формалинд хадгалаасласан гэмтэлтэй уушиг хүргүүлнэ.

5.4.7.2. Ийлдэс судлалын шинжилгээнд цусны ийлдэс явуулна.

5.4.8. **Бог малын мялзан** өвчний үед амьд малаас нүдний нулимс, нуух, хамар болон амны салст бүрхүүлээс дээж авна.

5.4.8.1. Үхсэн малаас уушиг, дэлүү, гэдэсний салст бүрхүүл, тунгалагийн зангилаа ялангуяа мөгөөрсөн хоолой, гэдэсний тунгалгийн зангилаанаас дээж авна.

5.4.8.2. Эмгэг эд судлалын шинжилгээнд уушиг, дэлүү, гэдэсний хэсэг, чацархайн тунгалагийн зангилааг формалины уусмалд авна.

5.4.8.3. Ийлдэс судлалын шинжилгээнд зориулж цусны ийлдэс илгээнэ.

5.4.9. **Сохор, догол** өвчний үед хамрын гоождос, арчдас, дэлэнгийн үрэвсэлтэй малын сүү, өвчилсөн нүдний нулимс, арчдас, үе мөчний шингэнийг илгээнэ.

5.4.9.1. Малыг хүүр буюу нядалсан малаас дэлэн, үений шингэн, уушиг, чээж, хэвлийн хөндийн шингэн ба тунгалгийн зангилаа илгээнэ.

5.4.9.2. Ийлдэс урвалын шинжилгээнд цус, цусны ийлдэс авч хүргүүлнэ.

5.4.10. **Скрепи** өвчний үед сэжигтэй хонь, ямааг нядласны дараа уртавтар тархийг авч 96% этанолд хадгалааслан хүргүүлнэ.

5.4.10.1. Эмгэг эд судлалын шинжилгээнд уртавтар тархины дундаас хажуугийн хөндлөн ховил хүртэлх хэсгээс няцлалгүй авч формальдегидын 4%-ийн уусмалд хадгалааслаж бэхжүүлээд шинжилнэ.

5.4.11. **Хонины бразотын** үед нян судлалын шинжилгээнд шинэхэн хүүрнээс элэг, дэлүү, бөөр, булчин, арьсны дорхи хавангийн шингэн зэрэг эрхтэн эдийн зүсэм, нарийн гэдэсний агуулагдахуун, ходоод, нарийн гэдэсний гэмтсэн хэсэг, хэвлийн хөндийн шингэн, чөмөгт яс илгээнэ.

5.4.11.1. Мөн элэгний өрцөн талын гадаргаас дардас бэлтгэж бэхжүүлээд явуулж болно.

5.4.12. **Дотрын халдварт хордлого, хурганы цусан суулгын** үед нян судлал ба хор илрүүлэх шинжилгээнд нарийн гэдэсний агуулагдахуун, хэвлийн хөндийн шингэн, чацархайн тунгалгийн зангилаа, цуллагийн эрхтний хэсгийг илгээнэ.

5.4.12.1. Эмгэгт материалыг мал үхмэгц авах ба үхснээс хойш 2 цагийн дараа авсан дээж шинжилгээнд тэнцэхгүй.

5.4.12.2. Өвчтэй малаас хор илрүүлэх шинжилгээнд 150–200 г чацга авна.

5.4.13. **Хонины тунгалгийн зангилааны идээт үрэвслийн** (Коринебактериоз) үед өвчилсөн болон үхсэн хонь, ямааны гэмтэлтэй тунгалгийн зангилаанууд, арьсны идээт шарх, буглаанаас авч хадгалааслалгүйгээр лабораторид хүргэнэ.

5.5. Гахайн өвчин

5.5.1. **Гахайн ёлом** өвчний үед гахайн шинэ хүүрнээс арьсны гэмтсэн хэсэг ба уушиг, дэлүү, бөөр, бүтэн зүрхийг явуулна. Энэ нь мялзан, цусан халдвар, иж балнад болон бусад өвчнөөс ялгаж танихад дөхөм үзүүлнэ.

5.5.1.1. Чөмөгт яс ба гэмтэлтэй үеийг задлахгүйгээр булчин махнаас нь салгаж явуулна.

5.5.2. **Гахайн халдварт энцефаломиелигийн** (Тешений өвчин) үед торойн хүүр, тархи, нугас, нугасны шингэн, цуллагийн эрхтэн зэргийг илгээнэ.

5.5.2.1. Гэдэсний гэмтэлтэй хэсэг, баас авч болно.

5.5.3. **Гахайн уушигны вируст үрэвслийн** үед уушигны өөрчлөлттэй хэсэг ба уушигны тунгалгийн зангилгаа, эмгэг эд судлалын шинжилгээнд дээрхи дээжийг формалины уусмалд бэхжүүлж илгээнэ.

5.5.4. **Гахайн үржил-амьсгалын замын хам шинж** өвчний үед хөхүүл торойн бүлэгнүүлсэн ба бүлэгнүүлээгүй цус, үхсэн торойн уушиг, гүйлсэн булчирхай, тунгалгийн зангилаа, дэлүү, хэвлийн шингэнийг дээжлэн илгээнэ.

5.5.4.1. Өсвөр торой, бодонгийн цусны ийлдэс, хээл хаясан мэгжний зулбадсыг цусны ийлдсийн хамт илгээнэ.

5.5.5. **Гахайн томуу** өвчний үед амьд гахайнаас хамрын гоождос, арчдас, нядалсан буюу үхсэн гахайнаас уушиг, мөгөөрсөн хоолойн салс авч хүргүүлнэ.

5.5.5.1. Ийлдэс судлалын шинжилгээнд зориулж цусны ийлдэс илгээнэ.

5.5.6. **Гахайн сонгомол мялзан** өвчний үед гүйлсэн булчирхай, уушиг, дэлүү, чацархайн тунгалгийн зангилаа, бөөр, бүдүүн гэдэсний цутгалангаас дээж авна.

5.5.6.1. Эмгэг эд судлалын шинжилгээнд гүйлсэн булчирхай, уушиг, дэлүү, чацархайн тунгалгийн зангилаа, бөөр, бүдүүн гэдэсний гэмтэлтэй хэсгээс авч формалины 10% -ийн уусмалд хадгалааслаад лабораторид илгээнэ.

5.5.6.2. Эсрэгбием илрүүлэх ЭЛИЗА урвалд зориулж амьд гахайн цусны ийлдэс хүргүүлнэ.

5.5.7. **Гахайн цэврүүтэх өвчин, гахайн амны цэврүүт үрэвсэл, гахайн цэврүүт эсэргэнэ өвчний** үед шүлхийн нэг адил дээж авах ба мөн баасны дээж авч хүргүүлнэ. Шүлхийтэй шинж тэмдгийн хувьд маш төстэй учир шүлхийн нэгэн адил анхааралтай хандана.

5.5.8. **Гахайн халдварт гастроэнтерит** өвчний үед амьд гахайнаас баас, үхсэн гахайнаас нарийн гэдэсний дээж явуулна.

5.5.8.1. Ийлдэс судлалын шинжилгээнд зориулж цусны ийлдэс илгээнэ.

5.6. Шувууны өвчин

5.6.1. **Ньюкаслийн өвчний** үед бүтэн хүүр юм уу хамар залгиурын арчдас, тархи, бөөр, дэлүү, уушиг, элэг, зүрх, агуулагдахуунтай гэдэс хүргүүлэх ба ЦНСУ–д зориулж ийлдсийн хос дээж авч явуулна.

5.6.1.1. Амьд шувуунаас мөгөөрсөн хоолой болон хам сүвний арчдас болон баасны дээж авна.

5.6.2. **Шувууны томуу, өндөр хоруу чанартай томуу** өвчний үед амьд шувуунаас хамар, залгиур, мөгөөрсөн хоолойн болон хам сүвний арчдас, баасны дээж авна.

5.6.2.1. Үхсэн юм уу нядласан үед тархи, мөгөөрсөн хоолой, уушиг, дэлүү, зүрх, нойр булчирхай, элэг, бөөр, гэдэсний дээж авна.

5.6.2.2. ЦНСУ, НТУ–д зориулж 2–4 долоо хоногийн дараа эдгэрэх үед авсан цусны ийлдэс авна.

5.6.2.3. Далд халдварыг илрүүлэхэд зориулж бүтэн өндөг лабораторид илгээнэ.

5.6.3. **Шувууны хламидиозын** үед бүтэн хүүр буюу цуллагийн эрхтнүүд (бөөр, уушиг, үнхэлцэг, дэлүү, элэг), шувууны сангас, гэдэсний агуулагдахуун илгээнэ.

5.6.3.1. Амьд шувуунаас нүдний арчдас, хамар, залгиурын болон хам сүвний арчдас авна. Бүх дээжийг авангуут буюу эсвэл зориулалтын тээвэрлэх орчинд хадгалааслаж хөлдөөлгүй лабораторид хүргэнэ.

5.6.3.2. Ийлдэс судлалын шинжилгээнд зориулж цусны ийлдэс илгээнэ.

5.6.3.3. Хүнд халдварлах эрсдэлтэй учир хамгаалалтын хувцас, хэрэгслийг бүрэн өмсөж биоаюулгүйн кабинетэд ажиллана.

5.6.4. **Шувууны микоплазмозын** үед үхээд удаагүй бүтэн хүүр, эсвэл түүний уушиг, мөгөөрсөн хоолой, хамрын хөндийн арчдас, агаарын уут, нулимс нуух, үеийн шингэн авах ба амьд шувуунаас нүд, хамар, залгиур, мөгөөрсөн хоолойн болон хам сүвний арчдас, хөврөлжиж байгаад үхсэн өндөгийг авна. Бүх дээжийг авангуут буюу эсвэл зориулалтын тээвэрлэх орчинд хадгалааслаж хөлдөөгөөд лабораторид хүргэнэ.

5.6.4.1. Ийлдэс судлалын шинжилгээнд цус буюу ийлдсийг илгээнэ.

5.6.5. **Шувууны халдварт ларинготрахеитын** үед амьд шувуунаас хамраас гарсан шингэн, нулимс, багалзуур, залгиур, хам савны арчдас авч илгээнэ.

5.6.5.1. Үхсэн шувууны хүүрнээс хамар, самсаа, ухархайн хөндий, мөгөөрсөн хоолой, агаарын хүүдий, уушиг болон үений шингэнээс авна. Мөн үр хөврөл нь үхсэн өндөг цуглуулж хүргүүлнэ.

5.6.5.2. Ийлдэс судлалын шинжилгээнд цусны ийлдэс хүргүүлнэ.

5.6.6. **Тахианы халдварт бронхитын** үед шувууны хүүр, уушиг, мөгөөрсөн хоолой, бөөр, багалзуурын арчдасыг илгээнэ. Дээжийг өвчний шинж тэмдэг илэрч байх үед нь авч даруй хөлдөөгөөд лабораторид хүргэх хэрэгтэй.

5.6.6.1. Ийлдэс судлалын шинжилгээнд зориулж цусны ийлдэс явуулна.

5.6.7. **Нугасны элэгний вируст үрэвсэл** үед дэгдээхэйн бүтэн хүүр буюу элэг, дэлүү, бөөр зэрэг эрхтнүүдийг илгээнэ.

5.6.8. **Нугасны гэдэсний вируст үрэвсэл** үед дэгдээхэйн бүтэн хүүр буюу элэг, дэлүү, бөөр зэрэг цуллагийн эрхтнүүдийг илгээнэ.

5.6.9. **Марекийн** өвчний үед бүтэн хүүр юм уу гепаринжуулсан цус, дэлүү элэг, тунгалгийн зангилаа зэргээс дээж авч хүргүүлнэ.

5.6.9.1. Ийлдэс судлалын шинжилгээнд ийлдэс бэлтгэж хүргүүлнэ.

5.6.10. **Шувууны сүрьеэ** өвчний үед бүтэн хүүр эсвэл эмгэгжсэн эрхтний хэсгийг нь авч хүргүүлнэ.

5.6.10.1. Эмгэгжсэн эрхтнүүдэд үүссэн идээд голомтуудаас хэд хэдэн түрхэц бэлтгэн илгээнэ.

5.6.11. **Шувууны цусан халдвар** өвчний үед бүтэн хүүр юм уу элэг, дэлүү, чөмөгт яс, зүрх, цус, шүүрдэс зэргийг авч хүргүүлнэ.

5.6.12. **Шувууны цэцэг** өвчний үед бүтэн хүүр юм уу арьсны гэмтэлтэй хэсгээс авч хүргүүлнэ.

5.6.12.1. Арьсны гэмтэлтэй хэсгээс хэд хэдэн наалдац түрхэц бэлтгэж илгээнэ.

5.6.13. **Шувууны пуллорозын** үед бүтэн хүүр юм уу өндөг, өндгөвч, цуллагийн болон тэжээл боловсруулах замын эрхтнүүдээс авч илгээнэ.

5.6.13.1. Ийлдэс судлалын шинжилгээнд зориулж цус, ийлдэс авч хүргүүлнэ.

5.6.14. **Гамборогийн өвчний** үед бүтэн хүүр юм уу элэг, бөөр, фабрициевын уутыг авч хүргүүлнэ.

5.6.14.1. Ийлдэс судлалын шинжилгээнд цус, ийлдэсний дээж авна.

5.6.15. **Тахианы спирохетозын** үед шувууны хүүрийг бүтнээр нь хүргүүлнэ.

5.6.15.1. Өвчтэй болон сэжигтэй хэд хэдэн тахианаас түлэгнүүлээгүй авсан цус, цусны түрхэцийг илгээнэ.

5.7. Нохой, муурын өвчин

5.7.1. **Алеутын өвчний** (булганы плазмозитоз) үед өвчтэй булгыг үхмэгц нь юм уу нядлаад элэг, дэлүү, чацархайн булчирхай, багалзуурын тунгалгийн зангилааг формалины 10 %-ийн уусмалд хадгалааслаж хүргүүлнэ.

5.7.1.1 Ийлдэс судлалын шинжилгээнд зориулж цус авч хүргүүлнэ.

5.7.2. **Нохойн гудрага өвчний** үед үхсэн нохойн цуллагийн эрхтэн, тунгалгийн зангилаа, тархи, уушиг, мөгөөрсөн хоолой зэргийг илгээнэ.

5.7.2.1. Амьд нохойн хамрын гоождос, нулимс нуух, баасны салс авна.

5.7.3. **Махчин амьтны эхинококкийн** үе хэсгийг илрүүлэх зорилгоор баас, бие гүйцсэн хорхойг илрүүлэх зорилгоор туулгах бодис олгосны дараа гарсан баасны дээж явуулна.

5.7.3.1. Эхинококк хүнд халдварлах, өвчлүүлэх аюултай учир эрсдлийг багасгах зорилгоор дээжийг -80°C -д 48 цаг, -70°C -д 4 хоног байлгах юм уу $+70^{\circ}\text{C}$ -д 12 цаг байлгана.

5.7.3.2. Хамгаалалтын хувцас заавал хэрэглэх ба ямар нэгэн халдваргүйжүүлэх бодис үйлчилдэггүй болохыг анхаарна. Бохирдсон эд материалыг аюулгүй болгохын тулд 85°C ба түүнээс дээш хэмээр үйлчлүүлнэ.

5.7.3.3. Лабораторийг аюулгүй болгохын тулд өрөөний чийгшилийг 40 хувь болтол бууруулж дулааныг 30°C хүртэл нэмэгдүүлж 48 цаг байлгана.

5.7.4. **Нохойн парвовирусийн халдварын** үед тархи, элэг, дэлүү, гэдэсний гэмтэлтэй хэсэг, амьд нохойноос баас авна.

5.8. Туулайн өвчнүүд

5.7.1. **Миксоматозын** үед үхсэн туулайн шинэ бүтэн хүүр эсвэл уушиг, зовхи, бэлгийн уруулын хавант хэсэг, арьсны эмгэгтсэн эдийг явуулна.

5.7.1.1. Анх өвчлөөд эдгэрсэн туулайнуудаас цус авч ийлдсийг ялгаад илгээнэ.

5.7.2. **Туулайн вирусын цусан халдвар** өвчний үед үхсэн туулайн бүтэн хүүр юм уу элэг, дэлүү, уушиг, бөөрийг бүтнээр авч хүргүүлнэ.

5.7.3. **Туулайн элэгний кокцидиозын** үед үхсэн буюу нядалсан туулайн элгийг цөсний уутны хамт лабораторид явуулна.

5.9. Бусад өвчнүүд

5.9.1. **Тэмээний цэцэг** өвчний үед арьс, ам хамрын салст бүрхүүл дээр гарсан цэврүүний шингэн, цэврүүний тав, гэмтэн арьсны эдээс авахын дээр эхэлж өвчилсөө тэмээнүүдээс цусны ийлдэс явуулна.

5.9.4. **Мал, амьтдын бабезиоз, тейлериоз, франсиллез, анаплазмозын** онош тогтоох шинжилгээнд захын судасны цуснаас нимгэн түрхэц бэлтгэх юм уу үл бүлэгнүүлэгчтэй цус авч хүргүүлнэ.

5.9.4.1. Түрхэц бэлтгэхдээ мал, амьтан халуурч эмнэл зүйн шинж тэмдэг өгч байгаа үед нь өвөрмөц эмчилгээ хийхээс өмнө цусыг авна.

5.9.4.2. Тейлериозын үед цуснаас түрхэц бэлтгэхээс гадна томорсон тунгалгийн зангилааг хатгаж гарсан шингэнээр нь түрхэц бэлтгэж явуулна.

5.9.4.3. Бабезиозын үед түрхэцийг нимгэн болон зузаан хэлбэрээр бэлтгэнэ.

5.9.4.4. Аль ч өвчний үед түрхэц бэлтгэхдээ эхний дусал цусыг ашиглана.

- 5.9.4.5. Түрхцээ нарны гэрэл, тоосноос хамгаалж чийггүй газар хатаагаад спирт, эфирийн адил хэмжээний холимог буюу метилийн спиртээр бэхжүүлнэ.
- 5.9.4.6. Нэг мал амьтнаас 2-оос доошгүй түрхэц бэлтгэнэ.
- 5.9.4.7. Ялзарч муудаагүй, шинэ хүүрнээс нимгэн түрхэц бэлтгэх бол тархи, чихний цус болон бөөр, дэлүү, элэг, зүрх, чөмөгнөөс бэлтгэнэ.
- 5.9.4.8. Ийлдэс судлалын шинжилгээнд цусны ийлдэс ирүүлнэ.
- 5.9.5. **Нийлүүлгийн өвчний** үед бэлгийн гадна эрхтний хавангийн шингэн болон сав, үтрээний салс, арьсны гүвдрүүний хусдас авч хэд хэдэн түрхэц хийж хүргүүлэх ба цусны ийлдэс явуулна.
- 5.9.5.1. Газар дээр нь шинжилгээ хийхдээ гүвдрүүний шингэн болон хусдаснаас шахмал дусал хийж шинжилнэ.
- 5.9.6. **Су ауру өвчний** үед чихний цуснаас түрхэц бэлтгэнэ.
- 5.9.6.1. Ийлдэс судлалын шинжилгээнд цус буюу цусны ийлдэс явуулна.
- 5.9.6.2. Үхснээс хойш 12 цагийн дотор хүүрийн элэг, дэлүү, бөөр, булчирхай, чөмөгнөөс налдац, түрхэц бэлтгэж болно.
- 5.9.7. **Трихомонозын** үед үнээний сав, үтрээний ялгадас, зулбадас, хээлийн шингэн ба хаг явуулна.
- 5.9.7.1. Бухны үрийн шингэн, мөн шамархайн зайлдасыг ариутгасан шил саванд хийж 24 цагийн дотор лабораторид хүргүүлнэ.
- 5.9.8. **Коккцидиозын** үед баас, гэдэсний гэмтсэн хэсэг хүргүүлнэ.
- 5.9.8.1. Жижиг мал амьтад шувууг бүтнээр нь хүргүүлнэ.
- 5.9.9. **Токсоплазмозын** үед дурандах шинжилгээнд тархи, цуллагийн эрхтэн, зулбадас, хээлийн шингэн, үтрээний ялгадас, нугасны шингэнийг явуулах ба дээжийг хөлдөөж болохгүй.
- 5.9.9.1. Амин сорилд эрхтний дээж авч явуулна.
- 5.9.9.2. Ийлдэс судлалын шинжилгээнд цус эсвэл ийлдэс хүргүүлнэ.
- 5.9.9.3. Хүнд халдварлах аюултай учир маш бологоомжтой харьцана.
- 5.9.10. **Гахайн балантидиозын** үед ашинэхэн баас, цэр мөгөөрсөн хоолойн салс явуулна.
- 5.9.11. **Шувууны гистомонозын** үед хам сүвийн баас, гэдэсний агуулагдахуунаас явуулна.
- 5.9.11.1. Элэгний үхжсэн хэсгээс дардас хийж явуулна.
- 5.9.12. **Цагаан хорхойн** өвчний үед 30–50 г шинэхэн баас хүргүүлнэ.
- 5.9.12.1. Трематод ба цестод, өргөст толгойтныг 70 хувийн спиртэнд, нематод, туузан хорхойн уулинхайг болон бөөрөнхий хорхойг Барбагаллогийн шингэнд бэхжүүлж хүргүүлнэ.
- 5.9.13. **Хамуу** өвчний үед дурандах шинжилгээнд арьсны гэмтсэн хэсгээс хусдас авч явуулна.
- 5.9.13.1. Демодекозийг шинжлэхэд булцрууны оройг зүүгээр хатгах юм уу зүсээд доторх агуулагдахууныг шахаж авах ба мөн 2 бодисын шилний хооронд хавчиж цаасанд боогоод хаяглаж хүргүүлнэ.
- 5.9.14. **Хачиг, шавжийг** 70 хувийн спиртэнд хадгалааслаж цаасан дээр балын харандаагаар хаяг бичиж дотор нь хийж ирүүлнэ.

5.10 Зөгийн өвчин

- 5.10.1. Өвчилсөн, үхсэн, амьд зөгий болон авгалдай, үрвэлдэйг дээж болгон авна.
- 5.10.2. Мөн зөгийн үүрний сархиагийг цаасан уутанд хийж явуулах ба нас гүйцсэн зөгийг хөлдөөж, эсвэл 70 хувийн этанолд хийж лабораторид хүргүүлнэ.
- 5.10.3. Зөгийн хоол тэжээлээс дээжлэнэ.

Зургаа. Дээж, эмгэгт материалын хэмжээ

- 6.1. Мал амьтны том жижгээс хамаарч нян, вирус, мөөгөнцрийн шинжилгээний дээж 1–10 г хэмжээтэй байна.

6.2. Нянгийн хор, мөөгөнцрийн хор, биохими, хор судлалын шинжилгээнд зориулсан эрхтний болон тэжээл, усны дээжийг 100–500 г хэмжээтэй авна.

6.3. Ийлдэс судлалын шинжилгээнд зориулж бог, бод мал, гахайнаас 5–10 мл, шувуу, үслэг ангаас 1–2 мл цус авна.

6.4. Нян, вирус, гэдэсний эгэл биетэнийг илрүүлэх шинжилгээнд мал, амьтны шинэхэн бааснаас 10 г дээж авна.

6.5. Цэврүүт өвчнүүдийн үед боломжтой бол 1-2 г хучуур эдийг 5 мл тээвэрлэх орчинд хийж явуулахын дээр цэврүүний шингэнээс ариун тариураар соруулж аваад хуруу шилэнд савлана.

6.6. Мал, амьтны эрүүл мэндийг хянах, тандах зорилгоор ийлдэс судлалын шинжилгээ хийхэд шаардлагатай дээжийн тоог статистик аргаар тооцож гаргана. Мал амьтны сүргийн өвчлөл, үхлийн шалтгааныг 95%-ийн магадлалтайгаар тогтоож чадах хэмжээгээр дээжийг сонгон авна.

Долоо. Эмгэгт материалыг савлаж бэлтгэх, илгээх, тээвэрлэх

7.1. Эмгэгт материалыг савлаж бэлтгэх, илгээх, тээвэрлэхдээ Зам тээвэр, аялал жуулчлалын сайдын 2006 оны 05 дугаар сарын 05–ны өдрийн 70 тоот тушаалаар батлагдсан “Биоаюултай илгээмж, биобэлдмэлийг тээвэрлэх журам”-ыг баримтлана.

7.2. Эмгэгт материалын боодол, савлалт нь Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага, Дэлхийн Амьтны Эрүүл Мэндийн Байгууллагаас гаргасан “Халдвартай зүйлс болон оношлогооны дээжүүдийг аюулгүй тээвэрлэх удирдамж”, Олон Улсын Агаарын Тээврийн Холбоо (IATA)–ны Савлагааны зааварчилгааны 602, 650 дугаар зааврын шаардлагыг хангасан байна.

7.3. Дээж илгээгч нь энэ зааврын Дөрөвдүгээр бүлгийн заалтууд, дээжийн гурван суурьт савлагаа, халдвар хамгааллын дүрмийг баримтлан ажиллах бөгөөд доорхи байдлаар савлаж тээвэрлэгчид хүлээлгэн өгнө.

7.3.1. *Эхний сав*: дээж агуулсан, шингэн гоожихоос хамгаалсан, ус нэвтрүүлдэггүй шил юм уу хуванцар сав байна. Гадны нөлөөллөөр гэмтэх хагарах тохиолдолд шингэнийг шингээгч материалаар хангалттай ороож хамгаалсан байна. Энэ савны хэмжээ 500 мл–ээс ихгүй байна.

7.3.2. *Хоёр дахь сав*: дээж бүхий савыг хамгаалах зориулалттай, бат бөх, шингэн гоожихоос сэргийлсэн, ус нэвтэрдэггүй төмөр юм уу хуванцар сав байна. Эхний савыг энэ саванд сайтар жийрэглэж байрлуулна.

7.3.3. *Гурав дахь сав*: Хоёр дахь савыг тээвэрлэлтийн явцад гэмтэх, норхоос сэргийлсэн нийлэг хатуу зүйлээр хийсэн сав байна. Хоёр дахь савыг хамгаалсан хөөсөнцөр хамгаалалттай байх ба тагийг цавуудаж бэхлэх юм уу наалддаг туузаар ороож нээгдэхээргүй болгоно.

7.3.4. Баглаа боодол нь дотор агуулагдах зүйлийг ямар ч тохиолдолд гадагш алдахааргүй байх, доргилт, хэм, чийг, даралтын өөрчлөлтөөс сэргийлж чадахаар байхыг илгээгч хариуцна.

7.3.5. Илгээгч биоаюултай илгээмж болохыг дүрслэсэн, хүн болон амьтанд нөлөөлдөг, халдвартай эсэхийг тодорхойлсон анхааруулга, таних тэмдгийг гурав дахь савны гадна талд наахын дээр хүлээн авагч болон илгээгчийн хаяг, холбоо барих утасны дугаарыг бичсэн байна. Дагавар бичиг, эвдэрч гэмтэх, осол гарах үед яаралтай холбоо барих

байгууллага, албан тушаалтны нэр, хаяг, утас, тээвэрлэгчийн мэдвэл зохих баримт зэрэг бусад мэдээллийг мөн тусгай дугтуйд хийж гадна хэсэгт наана.

7.4. Дагавар бичигт дараах мэдээллийг бүрэн тусгасан байна.

- Дээж явуулсан байгууллагын хаяг, утас, факс, Э - майл хаяг
- Дээж авсан мал, амьтны эзний хаяг, мал, амьтны төрөл, үүлдэр, нас, хүйс
- Дээж авсан он сар өдөр
- Ямар өвчний шинжилгээ хийлгэх
- Авсан дээжийн төрөл, хадгалаасласан эсэх
- Эпизоотологи, эмнэл зүйн шинж тэмдэг, эмгэг хувиралтын холбогдолтой мэдээлэл
- Эмчилгээ, вакцин, ийлдэс хэрэглэсэн эсэх

7.5. Биоаюултай илгээмжийг хилийн чанадад илгээх бол хүлээн авагч байгууллагаас импортлох зөвшөөрлийг урьдчилан авсан байна.

7.5.1. ДЭМБ-аас гаргасан удирдамжийн дагуу тээвэрлэлтийн явцад асгарсан тохиолдолд шингээх материал, халдваргүйтгэх уусмал бүхий шүршигч, гоожихоос хамгаалсан уут, ариун амны хаалт, резинэн бээлий зэргийг тээвэрлэгчид хүлээн өгнө.

Найм. Дээж, эмгэгт материал хадгалах

А. Үүсгэгч илрүүлэх (нян, вирус, паразит, прион) шинжилгээнд зориулсан дээж хадгалах:

8.1. Нян, вирус, паразит, прионыг илрүүлэх шинжилгээнд зориулан лабораторид ирүүлсэн бүх дээжийг халдвар үүсгэх чанартай гэж үзнэ.

8.2. Дээж эмгэгт материалтай тухайн лабораторийн эрх бүхий этгээдээс томилсон хүн харьцах ба өөр бусад хүн харьцахыг хориглоно.

8.3. Нян, вирус, паразит, прионыг илрүүлэх шинжилгээнд (халдварт өвчний оношлогоонд) зориулан авсан дээжийг шинжлэгч лабораторид илгээх хүртэл, мөн шинжлэгч лаборатори шинжилгээний эцсийн дүн (хариу) гарах хүртэл хугацаанд түр хадгална.

8.4. Халдварт өвчин үүсгэгч хүчин зүйлсийг хүн, мал, амьтанд аюул эрсдэл үүсгэх чанарыг харгалзан дөрөв бүлэглэх бөгөөд нян, вирус, паразит, прион бүхий дээжийг аль тохирох бүлгийн дээж хадгалах байранд зохих нөхцөлд хадгална.

8.5. Дээж материалыг хүн, мал амьтанд халдвар үүсгэхгүй байх, гадаад орчныг бохирдуулахгүй байх нөхцөл бүхий байр, орчинд хадгална.

8.6. Үүсгэгч илрүүлэх шинжилгээ бүрэн дууссаны дараа маргаан гарахгүй бол, цаашид ашиглахгүй бол (өсгөвөр, омог ялгах, вакцин оношлуур бэлтгэх, үзмэр бэлтгэх, эмгэгийн санг баяжуулах, судалгаа хийх) уг дээжийг шатаах буюу 121°C-д 20 минут чанаж бүрэн халдваргүйтгэн устгана.

Б. Ийлдэс судлалын шинжилгээнд зориулсан дээж хадгалах:

8.7. Хүн, мал амьтнаас авсан цусны ийлдэс, сийвэн, үтрээ болон шулуун гэдэсний салс, шүлс, үеийн шингэн, хэвлийн шингэн, махны шүүсийг жинхэнэ байдлаар хадгалах гурван аргын (1. сэрүүн = +4°C-ээс -6°C, 2. хөлдөөх = -20°C эсвэл -40°C-ээс -196°C, 3. хатаах = хуурайшуулах, эсвэл шингээгч цаасанд шингээх) аль боломжтойг сонгон зохих нөхцөлд хадгална.

8.7.1. Ийлдэс судлалын шинжилгээний дээжийг +4°C-д таван хоногоос ирүүгүй, -20°C-д нэг жилээс илүүгүй, -60°C-ээс бага тогтмол температурт хугацаагүй хадгална.

8.7.2. Хөлдөөж хадгалсан дээжийг хоёроос олон удаа гэгсгээж хөлдөөж болохгүй.

8.7.3. Хөлдөөж хуурайшуурсан ийлдсийг харануй сэрүүн орчинд хадгална.

8.7.4. Шингээгч цаасанд шингээж хатаасан ийлдсийг чийгэнд өртөхөөргүй битүүмжлэн харануй сэрүүн орчинд хадгална.

8.8. Хүн, мал амьтнаас авсан цусны ийлдэс, сийвэн, үтрээ болон шулуун гэдэсний салс, шүлс, үеийн шингэн, хэвлийн шингэн, махны шүүс Дээрх дээжийг хадгалааслагч бодис (азид натри 0.025%, тиамеросал 0.01%, борын хүчил 2%, фенол 0.5% г.м) нэмж хадгалаж болно. Хадгалааслагч бодис нэмсэн ийлдсийг +4°C-+6°C-д 1-2 жил хадгална. Гэвч хадгалааслагч бодис нь зарим шинжилгээний урвалд сөрөг нөлөөтэй учир энэ аргыг түгээмэл хэрэргэлдэдгүй.

8.9. Ийлдэс судлалын шинжилгээ бүрэн дууссаны дараа маргаан гарахгүй бол, цаашид ашиглахгүй бол (имуноглобулин ялгах, оношлуур бэлтгэх, ийлдсийн санг баяжуулах, судалгаа хийх) уг дээжийг 121°C-д 20 минут чанаж бүрэн халдваргүйтгэн устгана.

8.10. Дахин ашиглах дээж нэг бүрийг тухайн лабораториос кодлон дугаарлаж хадгалах ба тусгай бүртгэлд дээж цуглуулсан аймаг, сум (дүүрэг), баг (хороо), эзэн малчны нэр, мал амьтны төрөл, нас, хүйс, үүлдэр, хугацаа хэдийд авсаныг бүртгэн тэмдэглэсэн байна. Уг дээжийг хэзээ, ямар өвчний, ямар аргаар шинжилсэн, үр дүнг (эерэг, сөрөг) бичсэн байна.

Тодруулга. Санал хүлээн авах албан тушаалтан: Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн дэд захирал С.Цэрэнчимэд, утас 90027009, цахим хаяг: tserenchimed@scvl.gov.mn, Мал эмнэлэг, үржлийн газрын ахлах мэргэжилтэн Ц.Пүрэвхүү, утас 261601, цахим хаяг: purevkhuu@dvab.gov.mn

Төсөлтэй холбоотой саналыг хүлээн авагчийн цахим шуудангаар ирүүлнэ үү.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын
2018 оны ... дугаар сарын-ны өдрийн
хамтарсан тушаалын 2 дугаар хавсралт

**МАЛ ЭМНЭЛГИЙН ЛАБОРАТОРИД ОНОШЛОХ МАЛ АМЬТНЫ ӨВЧНИЙ
ЖАГСААЛТ**

№	Өвчний нэр
1	Адууны томуу
2	Арьс, лимфийн өвчин (LSD)
3	Африкийн адууны өвчин (AHS)
4	Бог малын мялзан (PPR)
5	Боом
6	Гахайн А хүрээний томуу
7	Гахайн сонгомол мялзан (CSF)
8	Гахайн үржил, амьсгалын замын хам шинж (PRRS)
9	Ньюкаслийн өвчин
10	Томуугийн А хүрээний вирус халдварууд
11	Үхрийн цээж (CBPP)
12	Хонь, ямааны цэцэг
13	Шүлхий (FMD)
14	Ямааны годрон (CCPP)
15	Аденоматоз
16	Гүүний иж балнад
17	Адууны нийлүүлгийн өвчин- <i>Dourine</i>
18	Адууны пироплазмоз - <i>B. equi</i> , <i>B. caballi</i>
19	Адууны ринопневмони (ER)
20	Адууны сахуу
22	Адууны тараагуур судасны үрэвсэл (EVA)
25	Адууны халдварт цус багадах өвчин (EIA)
26	Адууны хачгийн халуун
27	Адууны цэцэг
28	Адууны ям
29	Акараписоз
30	Актинобациллёз
31	Ауескийн өвчин
32	Африкийн гахайн мялзан (ASF)
33	Бактериологийн ерөнхий өсгөвөр
34	Баруун Нилийн чичрэг
35	Ботулизм
36	Бруцеллёз – <i>B. abortus</i> , <i>B. melitensis</i> , <i>B. suis</i>
37	Булчин цайх
38	Варрооз
39	Галзуу
40	Гахайн ёлом
41	Гахайн миксоплазмоз
42	Гахайн мялзан
43	Гахайн үржил АЗХШ
44	Дотрын халдварт хордлого
45	Дуут хавдар
46	Дэлэнгийн өмрөө-маммит
47	Зогсоо

48	Зөгийн гафиноз
49	Зөгийн үжил
50	Иод дутал
51	Кампилобактериоз
52	Колибактериоз
53	Ку чичрэг (Коксиелоз)
54	Лейшманиоз
55	Лептоспироз
56	Листериоз
57	Үхрийн иж сүрьеэ
58	Маеди-Висна (Ямааны үе тархины үрэвсэл)
59	Малын эндемик өвчнүүд
60	Марекийн өвчин (MD)
61	Найробын хонины өвчин (NSD)
62	Некробактериоз
63	Нипа вирус (NiV)
64	Нянгийн Ерөнхий тоо бохирдол
65	Нохойн гудрага
66	Өндөр хоруу чанартай шувууны томуу
67	Рифт хөндийн халуурал (RVF)
68	Салстын өвчин
69	Сальмонеллэз
70	Сохор догол
71	Сул хоруу чанартай шувууны томуу
72	Трипанасомоз Су-аура (T. evansi)
73	Үхрийн сүрьеэ -үхэр, шувуу
74	Тейлериоз
75	Токсоплазмоз
76	Трипаносомоз
77	Трихинеллэз
78	Туляреми
79	Туулайн вируст цусан халдвар
80	Туулайн миксоматоз
81	Тэжээлийн хордлого
82	Тэмээний амруу
83	Ургамлын хордлого
84	Үхрийн анаплазмоз
85	Үхрийн бабезиоз
86	Үхрийн вирусын диарей
87	Үхрийн мялзан
88	Үхрийн тархи сархиатах эмгэг (BSE)
89	Үхрийн үржлийн трихомоноз
90	Үхрийн халдварт ринотрахеит
91	Үхрийн хорт салтс халуурал
92	Үхрийн лейкоз (EBL)
93	Бугын херпес вирусын халдвар
94	Цаа бугын бруцеллез
95	Цаа бугын анаплазмоз-пироплазмоз
96	Цаабугын гууртах, цистицеркоз
97	Халдварт гастроэнтерит (TGE)
98	Хамуу

99	Хар араатах
100	Хачгийн рикетсиоз борреллиоз
101	Хачигт энцефалит
102	Хонины энзоот зулбах- хламидоз
103	Хонь, ямааны скрепи
104	Хордлогот өвчин
105	Хулгана яр
106	Хуцны эпидидемит
107	Хүнд металлын хордлого
108	Хэл хөхрөх (BT)
109	Цахлай
110	Цацрагийн хордлого
111	Цистицеркоз
112	Цусан халдвар (HS)
113	Шөвөг яр (Морцелиоз)
114	Шувууны микоплазмоз
115	Шувууны өндөр хоруу чанартай томуу (HPAI)
116	Шувууны сальмонеллэз
117	Шувууны халдварт бронхит (IB)
118	Шувууны халдварт ларинготрахеит (ILT)
119	Шувууны халдварт нефроз (IBD)
120	Эктопаразит - хамуу, демодекоз
121	Эндопаразит - цист, гельмент
122	Энтеробактериоз
123	Эргүү ценуроз
124	Ямааны артрит-энцефалит (CAE), маеди висна (MV)
125	Ямааны годрон
126	Яс сөнөрөх